

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл:
Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх даалгаврын
дугаар: 1в/1323 2025.04.17

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

“ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААХ ТУХАЙ ИРГЭДИЙН БАЙР СУУРИЙН ТАЛААРХ СУДАЛГАА” ШИФР: “ХЦА-2025”

Даалгаварт төслийн тайлан

Төслийн удирдагч: Ч.Баттулга - доктор (Ph.D),
профессор

Төслийн гүйцэтгэгчид: Ц.Дашзэвэг - ЭШТА, ҮБХИС-ийн
хүндэт доктор, профессор
Б.Энхбаясгалан - БХЭШХ-ийн БХСТ-ийн дарга, хурандаа,
Б.Балжинням - БХЭШХ-ийн БХСТ-ийн ЭШАА, хурандаа,
докторант
Б.Амартөр - БХЭШХ-ийн БХСТ-ийн ЭША, ахлах дэслэгч,
докторант

Захиалагч байгууллага: Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологи,
инновацын зөвлөл

Тайлан өмчлөгч:

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. 13320
Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 39-р хороо, Улаанхуарангийн
гудамж, Ахмадын болон алба хаагчдын хөгжлийн төв

ГАРЧИГ

УДИРТГАЛ	2-5
----------------	-----

Нэгдүгээр бүлэг.

Дэлхийн улс орнуудын хугацаат цэргийн албаны талаарх судалгаа	6-20
--	------

Хоёрдугаар бүлэг.

Монгол Улсын хугацаат цэргийн алба хаах өнөөгийн тогтолцоо, сургалт бэлтгэлийн агуулгад хийсэн шинжилгээ	21-36
--	-------

Гуравдугаар бүлэг.

Хугацаат цэргийн албаны талаарх нийгмийн сэтгэл зүйн чиг хандлага	37-44
--	-------

ДҮГНЭЛТ, зөвлөмж	45-51
------------------------	-------

НОМ ЗҮЙ

ХАВСРАЛТ

“Хугацаат цэргийн алба хаах тогтолцоо, шинэчлэл” сэдэвт социологийн судалгааны нэгдсэн дүн	53-69
---	-------

УДИРТГАЛ

Төслийн үндэслэл:

Хугацаат цэргийн алба нь Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 4-т заасан “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” гэсэн иргэний журамт үүргээ биелүүлэх, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшихтэй холбогдсон цэргийн жинхэнэ албанд татах, халах, алба хаах, бэлтгэл чөлөөнд байх харилцааг илэрхийлж буй өргөн хүрээтэй ойлголт юм.

Дэлхийн цэрэг, улс төр, аюулгүй байдлын орчны өөрчлөлт, чиг хандлага, үйл явцаас харахад цэргийн аюулгүй байдал, түүнийг хангах асуудалд улс орнууд ихээхэн анхаарах болжээ. Цэргийн аюулгүй байдлыг хангахад дайчилгааны үндсэн нөөц болох эх орноо батлан хамгаалах цэргийн хэргийн анхан шатны бэлтгэлтэй иргэдийг бэлтгэх хугацаат цэргийн алба чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 600 гаруй хууль байгаагаас цэргийн албатай холбоотой 14 хууль, 20 орчим хэм хэмжээний акт үйлчилж байна.

Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан “Цэргийн албаны тухай” хуулиар “Монгол Улсын иргэн 18-25 насны эрэгтэйчүүд хугацаат цэргийн албыг 12 сар хаах бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч онцгой нөхцөл бий болсон үед хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах хугацааг 3 хүртэл сараар сунгаж болно” гэж заасан.

Улс орны батлан хамгаалах чадавх, хүч нөөц, улс орны эдийн засгийн чадавх, нийгмийн хүчин зүйлс зэргийг харгалзан үзсэн, нийцтэй хугацаат цэргийн алба хаах оновчтой хэлбэр, хугацаа бүхий тогтолцоог бүрдүүлэх нь улс орны тусгаар тогтнол, цэргийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн чухал асуудлын нэг болоод байна.

Мөн цэргийн насны залуучуудын цэргийн албанаас зайлсхийх шалтгаан, нөхцөлд нийгмийн харилцаан дахь бусад олон хүчин зүйл нөлөөлдөг ч иргэн үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж цэргийн алба хаахад хугацаат цэргийн алба хаах хугацааны асуудал нь үндсэн нөлөөлөгч хүчин зүйл болдог.

Өнөөдөр манай улсын цэргийн насанд хүрсэн эрчүүдийн 7-8 хувь нь цэргийн албыг биер хааж, 10 орчим хувь нь дүйцүүлэх хэлбэрээр алба хааж байгаа гэсэн судалгаа байна. Өөрөөр хэлбэл алба хаах насны иргэдийн 20 хүрэхгүй хувь нь ямар нэг хэлбэрээр цэргийн алба хааж, 80 гаруй хувь нь цэргийн алба хаахгүй үлдэж, тэднийг цэргийн албанд хамруулах боломж ч байхгүй байгаа нь бодит байдал юм. Иймд шаардлага гарсан цагт эх орноо батлан хамгаалах бэлтгэлтэй иргэдийн нөөцийг нэмэгдүүлэхийн тулд алба хаах насны бүх эрчүүд цэргийн сургалт, бэлтгэлд хамрагдах нөхцлийг бүрдүүлэх, иргэдийн цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх, сонирхлыг бий болгоход чиглэсэн

эдийн засаг, нийгмийн хөнгөлөлт, урамшуулал, бусад давуу эрхүүдийг цэргийн албыг биеэр хаасан иргэдэд олгодог хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага байна.

Судлагдсан байдал:

1. Г.Мягмаржав. “Цэргийн сургалтыг эрчимжүүлэх сурган хүмүүжүүлэх үндсийн зарим тулгамдсан асуудал” сэдэвт докторын диссертаци (1995)
2. Г.Мягмаржав. “Цэргийн сургалтыг эрчимжүүлэх онол, практик” сэдвээр шинжлэх ухааны докторын диссертаци (2003)
3. “Зэвсэгт хүчний анги салбарын хугацаат цэргийн албан хаагчдын сахилга хариуцлагын байдал” төслийн ажил. БХЭШХ (2002)
4. “Хугацаат цэргийн албаны эрчимт сургалт” Шифр “Цэрэг” төслийн ажил. БХЭШХ. (2005)
5. “Цэргийн насны залуучуудын цэргийн албанаас зайлсхийх үзэгдлийн шалтгаан нөхцөл үр, дагавар, шийдвэрлэх арга зам” Шифр “Хугацаат цэргийн алба” төслийн ажил. БХЭШХ. (2009)
6. Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа – иргэд, цэргийн алба хаагчдын санал бодол сэдэвт төслийн ажлын тайлан (2005, 2006, 2008, 2012)
7. О.Үржин. “Хугацаат цэргийн албаны тогтолцооны шинэчлэлийн судалгаа” (2023)

Судалгааны объект: Хугацаат цэргийн алба хаах тогтолцоо

Судлах зүйл: Хугацаат цэргийн алба хаах тогтолцооны өнөөгийн байдал, түүний шинэчлэлийн талаарх иргэдийн байр суурь.

Судалгааны зорилго:

Хугацаат цэргийн алба хаах тогтолцоо, хэлбэр, агуулга, хугацааны талаарх шинжилгээ, судалгааны үр дүнд тулгуурласан санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны зорилт:

1. Дэлхийн улс орнуудын хугацаат цэргийн албаны талаарх судалгаа явуулах;
2. Хугацаат цэргийн алба хаах өнөөгийн тогтолцоо, сургалт бэлтгэлийн агуулгад шинжилгээ хийж, түүний давуу, сул талыг тодорхойлох;
3. Хугацаат цэргийн албаны талаарх нийгмийн сэтгэл зүйн чиг хандлагыг тодорхойлох;

4. Хугацаат цэргийн алба хаах тогтолцоог шинэчлэх боломжийн талаарх судалгаа явуулах санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүй:

Судалгааг явуулахдаа эмпирик арга зүйг удирдлага болгон чанарын болон тоон шинжилгээний аргыг хослуулан хэрэглэсэн бөгөөд баримт бичиг судлах, харьцуулан дүгнэх, бүлэглэх, социологийн судалгааны арга техник зэрэг нийгмийн шинжлэх ухааны нийтлэг аргыг ашиглав.

Социологийн судалгааг санамсаргүй түүврийн арга зүйг ашиглан 21 аймаг, Нийслэлийн 9 дүүргийн иргэдийн дунд анкетын асуулгын аргаар цахим хэлбэрээр “Google form” платформыг ашиглан 2091 хүнийг хамруулан явуулав.

Цахим судалгааны үр дүнд цугларсан мэдээллийг SPSS 26.0 программыг ашиглан боловсруулалт хийв.

Баримт бичгийн судалгааны хүрээнд гадаад улс орнуудын талаарх мэдээлэл, цахим орчин, статистик мэдээ, мэдээлэл, нийтлэл материал, холбогдох хууль, дүрэм, журам, тушаал шийдвэрүүдийг судлан үзэв.

Үндсэн ойлголтын тайлбар:

Цэргийн албаны тухай хуульд:

1. “цэргийн алба” - гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг;
2. “цэргийн жинхэнэ алба” - гэж Монгол Улсын иргэн цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүргийг биеэр гүйцэтгэхийг;
3. “цэргийн дүйцүүлэх алба” гэж Монгол Улсын иргэн шашин шүтлэг, ёс зүйн болон энэ хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн албыг дүйцүүлэн хаахыг;
4. “цэргийн жинхэнэ алба хаагч” - гэж цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа Монгол Улсын иргэнийг;
5. “хугацаат цэргийн алба хаагч” - гэж цэргийн албанд татагдан цэргийн байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэнийг;
6. “оюутан-цэрэг” - гэж цэргийн мэргэжил олгох сургалтад сайн дураар хамрагдаж байгаа их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагчийг;

7. “цэргийн жинхэнэ албанд татагдагч” - гэж цэргийн жинхэнэ албанд татах тухай зарлан дуудах мэдэгдэл авсан иргэнийг;
8. “нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн” - гэж цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч, ахлагч, офицерыг;
9. “хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн” - гэж цэргийн бүртгэлд байгаа цэргийн алба хаагаагүй эрэгтэйчүүд болон цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг тус тус ойлгоно.

Тайлангийн боловсруулалт, бүтэц хэмжээ:

Тайланг Монгол Улсын эрдэм шинжилгээний ажлын тайлан, бүтэц, шаардлага, MNS 2492:2004, MNS 5371:2004, ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлын заавар 2018 зэрэг баримт бичиг боловсруулалтын стандарт шаардлагад нийцүүлэн боловсруулав.

Төслийн ажлын тайлан нь удиртгал, гурван бүлэг, дүгнэлт бүхий 54 хуудас, хавсралт 5 хуудас материалуудаас бүрдэнэ. Тайлан нийт 60 хуудастай.

Тайлангийн удиртгалыг Ч.Баттулга, нэгдүгээр бүлгийг Б.Энхбаясгалан, Б.Амартөр хоёрдугаар бүлгийг Ч.Баттулга, Б.Энхбаясгалан, Б.Амартөр нар, дүгнэлт, зөвлөмжийг төслийн баг хамтран бичиж хийж гүйцэтгэв.

Социологийн судалгааны мэдээллийг Google form платформыг ашиглан цахим хэлбэрээр 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 05 дугаар сарын 19-ны өдрийн хооронд 21 аймаг, 9 дүүргийн 2091 иргэд, алба хаагчдаас цуглуулан SPSS-26.0 программ ашиглан Б.Энхбаясгалан, Б.Амартөр, Ч.Баттулга нар боловсруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНЫ ТАЛААРХ СУДАЛГАА

Дэлхийн зарим улс орнууд хугацаат цэргийн алба (ХЦА)-ыг биеэр хаах тогтолцоог эртнээс хэрэгжүүлж ирсэн уламжлалтай. Харин XXI зууны эхэн үед дэлхийн олон оронд цэргийн албыг заавал биеэр хаах эсвэл сайн дурын цэргийн албыг хослуулсан цэргийн албаны тогтолцоо хэрэгжиж эхэлсэн. Гадаадын улс орнуудад иргэдийн цэргийн алба хаах журам ч өөр өөрөөр хэрэгжиж байна. Ихэнх улс оронд эрэгтэйчүүд хуулийн дагуу цэргийн алба хаах ёстой гэж заасан байдаг бол эмэгтэйчүүд ерөнхийдөө сайн дурын үндсэн дээр цэргийн алба хаадаг байна. Одоогоор олон улсад цэргийн албыг биеэр зайлшгүй хаах тогтолцоотой 49 улс орон байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1.

Хугацаат цэргийн албыг иргэд заавал хаах тогтолцоотой улсууд

/д	Бүс нутаг	Улс орнууд	ЦАХ нас/хүйс	ЦАХ хугацаа/сар
1.	Ази	Камбож	18-30	18
2.		Казахстан	18-27	12-24
3.		Киргизстан	18-27	9-12
4.		Хойд Солонгос	17	Эрэгтэй 10 жил, эмэгтэй 5 жил
5.		Лаос	18	18
6.		Сингапур	18-21	24
7.		Өмнөд Солонгос	18-28 /30 нас	21-24/18-22 болгон бууруулахаар төлөвлөгдөж байгаа.
8.		Тайвань	18-36, 4 удаа 20 өдрийн цэргийн албаны сургалтад хамрагдана.	доод хугацаа 4 сар /12 сар болгосон
9.		Узбекистан	18-27	12
10.		Вьетнам	18-27	24-36
1.	Европ	Австри	18	6- 9
2.		Армен	18-27	24
3.		Беларусь	18-27	12-18
4.		Кипр	18-50	14
5.		Эстони	18-27	8-11
6.		Финланд	18	6-12
7.		Гүрж	18-27	12
8.		Грек	19-45	9-12
9.		Литва	19-26	9
10.		Молдова	18-27	12
11.		Норвег		19

12.		Орос	18-27	12
13.		Швед	18/ хүйс харгалзахгүй	7.5-15
14.		Швейцарь	18-30 нас, 245 хоногийн сургалтад заавал хамрагдана.	6 удаа 19 хоногоор (10 жилийн турш) дахин цэргийн албанд татах боломжтой.
15.		Тажикстан	18-27	24
16.		Турк	20-оос дээш насны	6-12
17.		Туркменистан	18-30	24-30
18.		Украин	20-27	12-24
1.	Африк	Алжир	19	24
2.		Марокко	19	12
3.		Чад	20 /эрэгтэй /21/ эмэгтэй	36/12
4.		Эритрей	18-40	18
5.		Өмнөд Судан	18	12-24
6.		Судан	18-33 эрэгтэй/эмэгтэй	12-24
7.		Тунис	20-35	12
1.	Ойрхи Дорнод	Египет	18-30	18-36
2.		Иран	18	18-24
3.		Израил	18	12-24
4.		Иордан	25-29	12
5.		Кувейт	18-35	12
6.		Катар	18-35	4-12
7.		Сири	18-42	18
8.		АНЭУ	18-30	16-24
1.	Өмнөд Америк	Боливи	18-22	12-24
2.		Бразил	18-45	10-12
3.		Колумб	18-24	18
4.		Куба	17-28	24
5.		Парагвай	18	12-24

Дээрх судалгаанаас харахад хугацаат цэргийн алба хаах зайлшгүй тогтолцоо Европ болон Ази тивийн улс орнуудад илүүтэй ажиглагдаж байна. Мөн түүнчлэн дээрх 49 улсын 50 гаруй хувь нь цэргийн алба хаах насыг 18-27 нас байхаар тогтоосон бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд заавал алба хаахаар заасан бол эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр алба хааж болохоор тусгажээ. Дээрх судалгааг хугацааны хувьд хураангуйлан дараах байдлаар (Хүснэгт 2) үзүүлж байна.

Хүснэгт 2.

Улс орнуудын ХЦА-ны тогтолцоог алба хаах хугацаагаар ангилан харуулсан байдал

Хугацаа	Улс орнууд	Тоо	Хувь
6-12 сар	ОХУ, Киргизстан, Тайвань, Узбекистан, Австри, Эстони, Финланд, Литва, Турк Катар, Бразил,	12	23%

	Швейцар		
12-18 сар	Камбож, Лаос, Кипр, Гүрж, Грек, Молдова, Швед, Швейцар, Марокко, Тунис, Иордан, Кувейт, Сири, Колумб, Украин	15	29%
18-24 сар	Казахстан, Сингапур, БНСУ, Армен, Беларусь, Норвег, Тажикстан Алжир, Эритрей Өмнөд Судан, Судан, Иран, Израил, АНЭУ, Боливи, Куба, Парагвай, БНХАУ, Япон	19	37%
24-өөс дээш сар	БНАСАУ, Вьетнам, Туркменистан, Чад, Египет	5	9%

Хугацаат цэргийн алба хаах тогтолцоотой улс орнуудаас зарим улсын алба хаах онцлогийг жишээ болгон авч үзье.

ОХУ: ОХУ нь тус улсын Ерөнхийлөгчийн зарлигаар заавал цэргийн алба хаах тогтолцоотой бөгөөд хугацаат цэргийн алба хаах, орлуулах, дүйцүүлэх хэлбэрээр 18-27 насны эрэгтэйчүүд цэргийн алба хаах үүрэгтэй бөгөөд жил бүр 18-27 насны 250 мянга гаруй залуус цэрэгт татагдаж 50 нас хүртэл нөөцөд байдаг байна.

1980-аад онд Афганистан болон Чечений дайнд туршлагагүй, дутуу бэлтгэгдсэн хугацаат цэргийн алба хаагчид олноор амь үрэгдсэн нь нийгэмд дайныг эсэргүүцэх үзлийг нэмэгдүүлээд зогсохгүй заавал цэргийн алба хаах тогтолцоог эсэргүүцсэн үзлийг өдөөсөн. 2007 онд алба хаах хоёр жилийн хугацааг нэг жил болгон бууруулсан ч олон залуусын хувьд зэвсэгт хүчинд алба хаах сонирхолгүй хэвээр байв. Харин 2022 оны 2 дугаар сард Орос Украинд цэрэг дайны ажиллагаа эхлүүлсний дараа Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу хугацаат цэргийн албан хаагчдыг Украин руу явуулахгүй гэж мэдэгдсэн ч дайн сунжирч хүн хүчний хувьд хохирол амсаж эхэлснээр хэсэгчлэн дайчилгааг зарлан хугацаат цэргийн албан хаагчдыг дайны газар оронд илгээсэн байдаг.

Цэргийн алба хаагаагүй бол төрийн алба хаших ажиллах эрхгүй бөгөөд цэрэг татлагаас оргон зайлсан тохиолдолд хоёр жил хүртэлх хугацаагаар шийтгэдэг хуулийн зохицуулалттай байна.

ОХУ-ын хуульд цэргийн алба хаасан бол улсын хэмжээний их дээд сургуульд “хялбар нөхцөлөөр” элсэн суралцах эрхтэй гэж заасан байдаг нь элсэлтийн шалгалтыг ярилцлагын хэлбэрээр солих эсвэл элсэлтийн шалгалтын тоог цөөрүүлэх зэргээр хөнгөлөлт үзүүлж байна.

Украин: 1992 оны 3 дугаар сарын 15-наас “Цэргийн үүрэг, цэргийн албаны тухай” хуульд 20-27 насны эрэгтэйчүүд хугацаат цэргийн алба хаах хугацааг яаралтай цэргийн

алба хааж буй цэрэг, тэнгисийн цэрэг, түрүүч, ахлагч нарын хувьд 18 сар хүртэл, дээд боловсролын магистрын зэрэгтэй иргэн цэргийн албыг 12 сар хүртэл хаах зохицуулалттай.

2000-аад оны эхээр тус улсын гадаад, дотоод аюулгүй байдлын орчин тогтвортой байсан тул цэргийн алба хаагчдын тоог бууруулсан. Украины Зэвсэгт хүчин 2012 онд шинэчлэлийг батлах хүртэл бараг өөрчлөгдөөгүй хэвээр байсан бөгөөд үүний дагуу таван жилийн дотор цэргийн албыг халж, цэргүүдийн тоог 190-ээс 70 мянга болгон бууруулахаар төлөвлөж байсан боловч 2014 онд Украины зүүн хэсэгт зэвсэгт мөргөлдөөн гарч, засгийн газар солигдож цэргийн дайчилгаа зарлаж, сайн дурын батальонуудыг байгуулжээ.

2020 оны байдлаар Украины Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчдын тоо 255 мянга, үүнээс 110 мянга нь гэрээгээр ажилладаг. Украины армийн нөөц 1 сая хүн байдгаас 150 мянга нь байлдааны ажиллагаанд оролцож¹, 80 мянга нь нутаг дэвсгэрийн хамгаалалт, 60 мянга нь Үндэсний гвард, 60 мянга нь Украины Аюулгүй байдлын алба, хилийн цэрэгт алба хаадаг бөгөөд дайчилгааны нөөц 36 мянган хүнтэй байна² гэсэн мэдээлэл байна.

Украины Ерөнхийлөгчийн “Бүх нийтийн дайчилгааны тухай” 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн №69/2022 дугаар зарлигаар улсын хэмжээнд бүх нийтийн дайчилгаа явуулж 18-60 насны эрэгтэйчүүдийг цэргийн албанд татсан.

Украины Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №1487 тоот тогтоолоор 2023 онд Украины нутаг дэвсгэрээс гадуур байгаа цэргийн алба хаах үүрэг хүлээсэн хүмүүс болон нөөцөд хамрагдах хүмүүсийг бүртгэх асуудал хууль тогтоомжоор албан ёсоор батлагдсан байна.

Норвег: Норвег нь НАТО-гийн анхны гишүүн орнуудын нэг төдийгүй НАТО-гийн умард хилийг хамгаалдаг улсын хувьд зэвсэгт хүчиндээ зарцуулж буй төсөв нь дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа байдлаараа АНУ-ын дараа орно³. 2000 оноос өмнө 19 настай эрэгтэйчүүд 12 сар цэргийн алба хаахыг үндсэн хуулиараа зааж өгсөн ч төсвийн зардлаас шалтгаалж алба хаах бүрэлдэхүүний тоог цөөлсөн. 2014 оноос хойш 19 нас хүрсэн л бол 44 нас хүртэлх эрэгтэй, эмэгтэй хүмүүс хүйсийн адил тэгш эрхтэйгээр цэргийн албыг 12-19 сарын хугацаатай хаадаг болсон ба цэргийн алба хаагчдын гуравны нэг нь эмэгтэйчүүд байдаг.

¹ <https://militaryarms.ru/armii-mira/vooruzhennyye-sily-ukrainy/>

² <https://dzen.ru/a/Y6r3yXXPsG4IZWwT>

³ <https://www.presscenter.mn/Niigem/delhii-dahin/norway>

Тус улсад жил бүр 60 мянга орчим иргэн цэргийн албанд бүртгүүлдэг бөгөөд үүнээс 8-10 мянга орчим нь буюу 15 орчим хувь нь цэргийн жинхэнэ алба хаадаг нь тус улсын төсвийн зарцуулалттай холбоотой юм⁴.

Цэргийн албыг дүйцүүлэх хэлбэрээр нийгмийн ажилд оролцож хааж болдог бөгөөд цэргийн албанд тэнцээгүй, чөлөөлөгдсөн иргэн 55 нас хүртлээ иргэний хамгаалалтын салбарт дүйцүүлэн алба хаадаг. Ингэхдээ гурван 7 хоногийн хугацаатай анхан шатны сургалтад хамрагдаж, дараа жил нь 2 өдрийн сургалтад хамрагдаж аливаа хямрал мөргөлдөөн гарвал дуудагдан үүрэг гүйцэтгэхэд бэлтгэгддэг⁵.

Хэрэв цэргийн алба хаахаас татгалзсан бол торгууль ноогдуулах, эсвэл 2 жил хүртэлх хугацаагаар хорих шийтгэл хүлээдэг.

Цэргийн алба хаах хугацаа нь 12-19 сарын хугацаатай Норвеги улсыг гадны хүчнээс хамгаалахын тулд сургалтын хугацаанд бүх зүйлсийг сурч мэдэхэд шаардлагатай хугацаа гэж үздэг. Тусгай мэргэжлийн албан хаагчдыг сургахад удаан хугацаа, нөөц их шаарддаг албан тушаалд тухайн албан хаагчийн ур чадвар, алба хаах хүсэл эрмэлзэлд нь үндэслэн зарим цэргийн албан хаагчдын хугацааг 16 сараар сунгадаг. Хэрэв цаашид алба хаах хүсэлтэй бол сайн дурын үндсэн дээр мөн сунгаж болно⁶. Энэ нь Норвегийн арми хүний тооноос илүү чанартай мэргэшсэн байх гэсэн үзэл баримтлалыг цэргийн албан хаагчдад тавьж буйн илрэл юм⁷.

Цэргийн алба хааснаар тухайн иргэн цааш цэргийн албандаа үргэлжлүүлэн ажиллаж болох бөгөөд эсвэл иргэний амьдралд шилжиж зарим нийгмийн хамгааллын үйлчилгээг үнэ төлбөргүй авах, хөнгөлөлт эдлэх зэрэг эрх нь үүсдэг.

Швейцар: Швейцар нь цэргийн албыг биеэр хаадаг улсуудын нэг бөгөөд эрэгтэй хүн бүр 18-24 насандаа заавал цэргийн алба хаадаг бол эмэгтэйчүүд сайн дураараа хаадаг⁸. Сүүлийн 100 гаруй жил төвийг сахих статустай, удаан хугацаанд огт дайн байлдаанд оролцолгүй явж ирсэн энэ улсын төр засаг цэрэг зэвсэглэлийн төсвийг төдий л дэмжихгүй байсан ба 2013 оны 9 дүгээр сарын 22-нд Швейцарт сайн дурын үндсэн дээр цэргийн алба хаах тухай бүх нийтийн санал асуулга явуулсан бөгөөд санал хураалтад оролцсон иргэдийн 73 хувь нь буюу дийлэнх нь цэргийн алба хаахыг дэмжсэн байна⁹.

⁴ <https://www.forsvaret.no/en/news/articles>

⁵ <https://ebco-beoc.org/norway>

⁶ <https://folkogforsvar.no/verneplikten-i-utvikling/>

⁷ <https://thenorwayguide.com/military-conscription/#:>

⁸ <https://web.archive.org/web/20090502061315/http://www.vtg.admin.ch/internet/vtg/fr/home/militaerdienst/rekrut.html>

⁹ <https://www.bk.admin.ch/ch/d/pore/va/20130609/det570.html>

Тухайн иргэн тодорхой хүндэтгэн үзэх шалтгаанаар цэргийн алба хаах хугацааг 4 жилээр хойшлуулж болох бөгөөд хэрэв энэ хугацаанаас хэтрүүлбэл торгууль ноогдуулдаг. Цэрэг татагдахын өмнө тодорхой сургалтад хамрагдаж цэргийн алба хаах хугацаанаас хасуулж болдгоороо онцлогтой. Цэрэгт татагдсан бүрэлдэхүүнийг бие бялдар, оюуны чадавх ур чадвараар нь өөр албан тушаалд томилдог. Цэргийн алба нь 245 хоногийн турш үргэлжилдэг бөгөөд алба хаасны дараа 10 жилийн хугацаанд нөөцөд авдаг¹⁰.

Цэргийн жинхэнэ албанд тэнцсэн боловч тодорхой шалтгаанаар алба хаах боломжгүй иргэдэд зориулж цэргийн албыг дүйцүүлэх зэргээр өөр хэлбэрээр хааж болох зохицуулалтыг бий болгосон. Тухайлбал дүйцүүлэх алба нь соёлын дурсгалт газруудыг сэргээн засварлах, ахмад настанд туслах зэрэг нийгмийн бусад сайн дурын ажлыг 340 хоног хийдэг байна. Цэргийн албанд тэнцээгүй цэргийн алба хаагчийг цэргийн албанаас бүр чөлөөлдөггүй бөгөөд иргэний хамгаалалт, цагдаа, гал түймэр, эрүүл мэндийн туслах ажилтан, байгалийн гамшгийн үед тусламж үзүүлэх, жагсаал цуглаан болсон үед түүнийг хянан зохицуулах зэрэг ажилд сурган татан оролцуулдаг¹¹.

Вьетнам: Вьетнамын хугацаат цэргийн албанд 18-25 насны бүх эрэгтэйчүүдийг цэргийн алба заавал биеэр хаахыг, эмэгтэйчүүд сайн дураараа цэргийн алба хаах эрх зүйн зохицуулалттай¹². Вьетнамын Ардын Арми нь 492 мянган хугацаат цэргийн алба хаагчтай бөгөөд хүн амын 0,64 хувийг эзэлдэг. Жил бүр ойролцоогоор 770 мянга орчим 18-27 насны эрэгтэй 2 жилээр¹³ алба хаадаг бөгөөд их дээд сургууль, коллежид суралцдаг бүрэлдэхүүн ч мөн хаадаг. Зарим тохиолдолд цэргийн алба хаах хугацааг БХЯ-ны сайд 6 сар хүртэлх хугацаагаар байлдааны бэлэн байдлыг хангах, байгалийн гамшиг, тахал өвчин эмгэгтэй тэмцэх, аврах, сэргээн босгох ажиллагааны үед сунгаж болдог. 1990 оноос цэргийн албыг 3 жил хаадаг байсныг бууруулж 2 жил болгосон байдаг. Энэ нь *нэгдүгээрт* улсын аюулгүй байдлын орчны нөхцөл сайжирсан, *хоёрдугаарт* эдийн засгийн нөхцөл байдал, батлан хамгаалах салбарт зарцуулах төсвийг хэмнэх, *гуравдугаарт* хагас цэрэгжүүлсэн, нөөц хүчний бүрэлдэхүүнийг хямд зардал төсвөөр бэлтгэх болсонтой холбоотой гэж үздэг байна.

2015 онд батлагдсан “Цэргийн алба хаах тухай хууль”-д дараах нөхцөлүүдийг цэргийн жинхэнэ алба хаасанд тооцдог байна. Үүнд:

¹⁰ https://www.thesoldiersproject.org/countries-have-compulsory-military-service/#39_Switzerland

¹¹ <https://www.vtg.admin.ch/en/mein-militaerdienst.html>

¹² <https://e.vnexpress.net/news/news/2-vietnamese-men-face-criminal-charges-for-dodging-military-service-twice-3541643.html>

¹³ <http://tanssonhi.tanphu.hochiminhcity.gov.vn/tin-tuc-su-kien/hop-mat-quan-nhan-xuat-ngu-nam-2021-c7-9550.aspx>

- Вьетнамын эргийн хамгаалалтын албанд алба хааж нийтийн аюулгүй байдлыг хамгаалах байгууллагад элссэн;
- 36 сарын хугацаанд цагдаагийн байгууллагад сайн дурын ажилд оролцсон;
- их дээд сургууль төгссөн эдийн засаг-батлан хамгаалахын чиглэлээр 24 сараас дээш хугацаанд сайн дурын ажилд оролцсон;
- Загас агнуурын усан онгоцонд бүтэн 24 сар ба түүнээс дээш хугацаагаар ажилласан иргэд¹⁴ зэрэг болно.

1989 онд Камбожтой хийсэн дайн дууссанаас хойш Вьетнамын үндэсний аюулгүй байдал хилийн мөргөлдөөн зэрэг доод түвшин рүү шилжиж хагас цэрэгжүүлсэн хүчнийг өргөжүүлэх нь байнгын армийг хуучин түвшинд байлгахаас хамаагүй хямд өртөгтэй гэж үзсэн байна¹⁵. Үүнтэй холбогдуулан 1996 онд нөөц хүчнийг хөгжүүлэх, дайчлахтай холбогдсон цэргийн нөөцийн тухай шинэ хууль батлагдсан. Нөөцийн үүрэг нь эрэгтэйд 45 нас хүртэл, эмэгтэйд 40 нас хүртэл хамаарна. Дээр дурдсан хагас цэрэгжүүлсэн хүчинд нөөцийн албыг гүйцэтгэж болно. Ардын өөрийгөө хамгаалах цэрэг буюу нөөц хүчин нь 4-5 сая орчим бие бүрэлдэхүүнтэй¹⁶. Хагас цэрэгжүүлсэн нөөцийн хүчин нь сүүлийн жилүүдэд Вьетнамын батлан хамгаалах стратегийн чухал элемент болоод байна.

Цэргийн албанаас татгалзсан бол эхний удаа торгууль ноогдуулдаг бөгөөд дараагийн удаа гурван сараас 2 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэдэг байна.

БНХАУ: Бүгд Найрамдах Хятад Ард Улс 1955 оны 7 дугаар сарын 30-ны өдөр “Цэргийн албаны тухай хууль”-ийг баталж, цэргийн алба хаах нь иргэний эрх төдийгүй иргэний үүрэг мөн гэж заасан байдаг. 1978 оны 3 дугаар сард цэргийн алба хаах тогтолцоог хугацаат цэргийн алба хаагч, сайн дурын ажилтныг хослуулах болгон өөрчилсөн.

1984 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан “БНХАУ-ын Цэргийн албаны тухай хууль”-д цэргийн жинхэнэ алба хаахыг сайн дурын алба болгосон. 1998 оны 12 дугаар сарын 29-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан “БНХАУ-ын Цэргийн албаны тухай хууль”-д цэргийн алба хааж байгаа цэргийг сайн дурын цэрэг, цэргийн нөөцийн албатай хослуулан цэргийн алба хаах тогтолцоог хэрэгжүүлэхээр заасан. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд үндэс угсаа, арьсны өнгө, эрхэлсэн ажил, гэр бүл, шашин шүтлэг, боловсролын түвшин харгалзахгүйгээр хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэй. Цэргийн алба нь жинхэнэ алба, нөөцийн алба гэж хуваагддаг. 18-22 насны эрчүүдийг

¹⁴ https://moj.gov.vn/vbpq/lists/vn%20bn%20php%20lut/view_detail.aspx?itemid=30514

¹⁵ https://wri-irg.org/en/programmes/world_survey/country_report/en/Vietnam

¹⁶ <https://wri-irg.org/en/story/2002/concluding-observations-human-rights-committee-viet-nam>

цэргийн жинхэнэ албанд, 18-22 насны эмэгтэйчүүдийг цэргийн хэрэгцээ, сайн дурын зарчмаар жинхэнэ албанд 2 жил алба хаалгадаг байна. Идэвхтэй алба хаах хугацаа дууссаны дараа арми болон сайн дурынхны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайн дурын алба хаагчид (мөн бага офицер гэж нэрлэдэг) болдог байна. Цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн 18-35 насныхан цэргийн нөөцөд алба хаана. Цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн хугацаат цэргийн албан хаагчид дунд мэргэжлийн сургуульд шалгалтгүйгээр элсэх, энгийн дээд сургуульд элсэх, насанд хүрэгчдийн боловсрол эзэмшсэн хүмүүс урамшууллын оноо болон бусад хөнгөлөлттэй бодлого, төрийн тэтгэлэгт хамрагдах боломжтой. Дайны үеийн онцгой нөхцөлд 36-45 насны эрэгтэйчүүдийг жинхэнэ албанд татан оролцуулж болно.

Хятадын цэргийн алба хаах тогтолцоо нь заавал алба хаах болон сайн дурын алба хаах гэсэн хоёр хэлбэрт хуваагддаг. БНХАУ-ын Цэргийн албаны тухай хуульд “Эх орноо хамгаалах, түрэмгийллийг эсэргүүцэх нь БНХАУ-ын иргэн бүрийн ариун үүрэг мөн”¹⁷ гэж заагаад сайн дурын үндсэн дээр болон тусгай гэрээгээр алба хаах цэргийн албаны тогтолцоог хэрэгжүүлнэ”¹⁸ гэж заажээ.

Цэргийн албыг жинхэнэ алба, нөөц гэж хуваадаг бөгөөд идэвхтэй алба хааж байгааг жинхэнэ цэргийн алба хааж байгаа, урьдчилан татагдсан эсвэл нөөцөд алба хааж байгаа хүмүүсийг нөөцийн албан хаагч гэж нэрлэдэг. “18 нас хүрсэн эрэгтэйчүүдийг жинхэнэ албанд татна, тухайн жил татагдаагүй бол 22 нас хүрэхээс өмнө жинхэнэ албанд татагдаж болно. Энгийн дээд сургуулийн төгсөгчдийг элсүүлэх насыг 24 нас хүртэл, төгсөгчдийг элсүүлэх насыг 26 нас хүртэл хойшлуулж болно. Армийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмэгтэйчүүдийг цэргийн жинхэнэ албанд татан оролцуулж болно. 17 нас хүрсэн боловч 18 нас хүрээгүй иргэдийг цэргийн хэрэгцээ, өөрийн хүсэлтээр цэргийн жинхэнэ албанд татаж болно”¹⁹ гэжээ.

“Хугацаат цэргийн жинхэнэ алба хаах хугацаа хоёр жил байна”²⁰. Х бүлгийн 57 дугаар зүйлд “Цэргийн алба хаах үүрэг хүлээсэн иргэд дор дурдсан үйлдлүүдийн аль нэгийг үйлдсэн бол хошууны түвшний ардын засгийн газар тэдэнд заасан хугацаанд засаж залруулахыг, хэрэв заасан хугацаанд засаж залруулахгүй бол ардын засгийн газар мужийн түвшин тэднийг цэргийн алба хаах үүргээ биелүүлэхийг албадаж, торгууль ногдуулна. Үүнд: 1). Цэргийн албанд бүртгүүлэхээс татгалзах буюу зайлсхийх, 2). Идэвхтэй алба хаахаас татгалзсан буюу зайлсхийсэн иргэд, 3). Нөөцийн албан хаагчид цэргийн бэлтгэлд оролцох, байлдааны бэлэн байдлын үүрэг гүйцэтгэх, байлдааны бус ажиллагааны

¹⁷ 中华人民共和国兵役法. http://www.mod.gov.cn/regulatory/2021-08/20/content_4892491.htm

¹⁸ 中华人民共和国兵役法. http://www.mod.gov.cn/regulatory/2021-08/20/content_4892491.htm

¹⁹ 中华人民共和国兵役法. http://www.mod.gov.cn/regulatory/2021-08/20/content_4892491.htm

²⁰ 中华人民共和国兵役法. http://www.mod.gov.cn/regulatory/2021-08/20/content_4892491.htm

даалгавар гүйцэтгэх, элсүүлэхээс татгалзах буюу зайлсхийх эдгээр болно. Өмнөх хэсгийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг үйлдэж, залруулга хийхээс татгалзсан этгээдийг төрийн албан хаагч болон “БНХАУ-ын Төрийн албан хаагчийн тухай хууль”-ийн дагуу удирдах албан тушаалтнаар ажилд авахгүй эсхүл төрийн өмчит үйлдвэрийн газар, байгууллагын ажилтнаар ажиллуулж, хоёр жилийн дотор хилээр гарахыг хориглох, сургуульд сурч, сургуульдаа буцаж ирэхийг хориглож, улс орны батлан хамгаалах үүргээ биелүүлэхээс татгалзсан ноцтой хүмүүсийн жагсаалтад оруулдаг байна. Мөн цэргийн албанаас зайлсхийж, үүргээ биелүүлэхээс татгалзсан, цэргээс оргон зайлсан цэргүүдийг Цэргийн төв зөвлөлийн тогтоолын дагуу шийтгэдэг”²¹ байна.

БНСУ: БНСУ-ын Үндсэн хуульд “Хуульд заасан нөхцөлөөр бүх иргэн улс орноо хамгаалах үүрэгтэй гэж заасан бөгөөд 18-37 насны эрэгтэйчүүд заавал алба хаах бөгөөд хуурай замын цэрэгт алба хаах хугацаа 18 сар, Тэнгисийн цэрэгт 20 сар, Агаарын цэрэгт 22 сар алба хаадаг байна. Хугацаат цэргийн алба орлуулах, дүйцүүлэх хэлбэрээр 18-35 насны эрэгтэй иргэн бүр цэргийн алба хаах үүрэгтэй. Цэргийн алба хаасан иргэд бэлтгэл үүрэгтний бүртгэлд 4 жил, дараа нь дайчилгааны нөөцөд 4 жил хамрагдана. Олон улсын нэр хүндтэй мэргэжлийн тамирчид, дуучдыг цэргийн албанд өөрсдийн ур чадварт тохирсон ажлыг хийхийг зөвшөөрдөг. Шашин шүтлэг, ёс зүйн шалтгаан байвал цэргийн албыг дүйцүүлэн хааж болно хэмээн хуульчилсан байдаг. Христийн шашны Еховагийн гэрч урсгалыг баримтлагч сүсэгтнүүд цэрэгт явахгүй гэж өргөдөл гаргадаг. Эдгээр хүмүүсийг хуулиар нийтийн ашиг сонирхлын чиглэлээр болон үйлчилгээний албанд /шорон гэх мэт/ 36 сар ажиллуулах замаар дүйцүүлж алба хаахыг зөвшөөрдөг. Орлуулах, дүйцүүлэх албаны хугацаа 36 сар байна. Манайхаас ялгаатай нь цэргийн дүйцүүлэх алба нь биеэр дүйцүүлэх хэлбэрийг зөвшөөрнө, харин мөнгөн төлбөрийн хэлбэрээр хаах гэсэн ойлголт байдаггүй. Эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн алба хаах боломжгүй эрчүүд хүмүүнлэгийн болон нийгэмд тустай ажил хөдөлмөрт оролцох замаар орлуулан цэргийн алба хаахыг зөвшөөрдөг байна.

Тайвань: Тайваний хугацаат цэргийн алба нь 1945 оны 1 дүгээр сард Японы ноёрхол эцэс болсны дараа 1949 оны 12 дугаар сараас цэрэг татлагын тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. Алба хаах хугацааг 1949-1987 онд армид 2 жил, тэнгисийн цэргийн болон нисэх хүчинд 3 жил гэж тус тус тогтоосон. 1987 оноос 1990 оны 6 дугаар сар хүртэл тэнгисийн цэрэг, агаарын хүчин 2 жил, арми 3 жил алба хаах болсон. 1990 оны 7 дугаар сараас эхлэн бүх цэргийн албыг 2 жил болгосон. 2000 оны 1 дүгээр сараас хугацаа нь 1

²¹ 中华人民共和国兵役法. http://www.mod.gov.cn/regulatory/2021-08/20/content_4892491.htm

жил 10 сар болж, дараа нь жил ирэх тусам буурч 2008 оны 1 дүгээр сар хүртэл 1 жил болж буурсан. 2013 оны 2 дугаар сараас 4 сарын цэргийн бэлтгэлд хамрагдаж, алба хаах ёстой гэж тогтоосон. Гэвч Тайвань 2022 онд 2005 оноос хойш төрсөн эрэгтэйчүүдийн цэргийн алба хаах хугацааг 1 жил болгон уртасгахаар болсноо зарласан байна.

Тайваний нийгэмд цэргийн алба хаах хугацааг уртасгах талаар зөвшилцөлд хүрсэн ч ялгаа их байна. Тайваний олон нийтийн санал асуулгын 2022 оны 12 дугаар сарын 20-нд гаргасан санал асуулгын дүнгээр нийт оролцогчдын 73.2% нь цэргийн албыг нэг жил болгохыг зөвшөөрсөн бол 17.6% нь эсэргүүцсэн бөгөөд 20-24 насны санал асуулгад оролцогчдын дөнгөж 35.6% нь зөвшөөрч, 37.2% нь санал өгсөн байна.

2022 онд Орос-Украины дайн дэгдсэн нь “Өнөөдөр Украин, маргааш Тайвань” гэсэн болгоомжлолыг төрүүлсэн төдийгүй ирэх таван жилийн дотор Хятад улс Тайваньд халдаж магадгүй гэж зарим шинжээч үзэж байна. Эдгээр хүчин зүйл нь үндэсний армийн хүч чадлыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулсан учир 2022 оны 12 дугаар сард цэргийн алба хаах хугацааг сунгах талаар зарласан. Судлаачдын тооцож байгаагаар Тайваньд цэргийн аюул заналхийлэл нэмэгдэж, төрөлт буурч байгаа нь Тайванийн цэргийн хүчин чадлыг бууруулж, хугацаат цэргийн албыг сунгахад хүргэж байна.

Тайваны цэргийн алба хаах тухай хуульд зааснаар цэргийн алба хаах хүмүүс цэргийн жинхэнэ албаны үзлэгт тэнцсэн, цэргийн жинхэнэ албанд сайн дураараа оролцох 19 нас хүрсэн эрэгтэй цэргийн бүртгэлд хамрагдана”²² гэж заажээ. Мөн “Цэргийн албаны тухай хуульд алба хааж байгаа болон байнгын цэргийн бэлтгэл сургуулилтад хамрагдаж байгаа, өмнө нь ажиллаж байгаагүй оюутан, албан хаагчид сургалтын хугацаа дуусахад, тэдний сургуулийн асуудлыг боловсролын яам, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төв байгууллага хариуцахаар заасан байна. Тухайлбал өргөдөл гаргах, зарлан дуудах үед үндсэн сургууль, төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага хэвээр байгаа бол тухайн албан тушаалын анхны зэрэг, ажилласан хугацааны дагуу сургууль, ажилдаа эргэн орно. Анхан шатны сургууль, агентлаг, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага байхгүй эсвэл өмнө нь ажиллаж байгаагүй бол эрх бүхий байгууллага нь бусад сургууль, төрийн байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад сургуульд суралцах, ажилд авах талаар зөвлөгөө өгөх, зохион байгуулахад давуу эрх олгоно.

Мөн цэргүүд алба хаах хугацаандаа чөлөөт цагаараа ахисан болон нэмэлт сургуульд суралцах боломжтой бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээг БХЯ, Боловсролын яамтай хамтран боловсруулна”²³. Тус хуулийн 8, 12 дугаар зүйлд заасны дагуу дүйцүүлэх

²² 台湾兵役法 . 2019.<https://law.moj.gov.tw/LawClass/LawAll.aspx?pcode=F0040002>

²³ 台湾兵役法 . 2019.<https://law.moj.gov.tw/LawClass/LawAll.aspx?pcode=F0040002>

алба хаах албанд шилжсэн хүмүүсийн хувьд цэргийн албанд бүртгүүлсэн болон цэргийн бэлтгэлд хамрагдсан, эсхүл жинхэнэ алба хаасан хугацааг дүйцүүлэх алба хаах хугацаа болгон сольж болно”²⁴ гэжээ.

Финланд: Финланд улсын Үндсэн хуулиар иргэн бүрийн биелүүлэх журамт үүргийн дагуу 18-60 насны эрэгтэй иргэн бүр цэргийн алба хаах үүрэгтэй 18 нас хүрсэн Финланд улсын иргэн “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” эмэгтэйчүүд цэргийн албанд сайн дураар 165, 255, 347 хоног алба хаах боломжтой. Цэргийн албыг цэргийн /military service/ ба цэргийн бус /non-military service/ гэсэн хэлбэрээр хаадаг. Тусгай ур чадвар шаарддаггүй цэргийн мэргэжлийн ангилалд алба хаагчид анхан шатны сургалтад 8 долоо хоног хамрагдаж дууссаны дараа төрөл мэргэжлийн цэргийн ангиудад хуваарилагдан тусгай бэлтгэлд хамрагдах ба нийт 5 сар хагас (165 хоног) алба хаадаг. Техник, технологийн өндөр мэргэжил шаардлагатай цэргийн мэргэжлийн ангилалд алба хаах хугацаа нь 8 сар хагас (255 хоног) байна. Цэргийн бус алба (non-military service) нь зарим тусгай мэргэжлийн офицер, ахлагчийг бэлтгэх сургалт бөгөөд хамрагдахаар сонгогдсон иргэд 9-12 сар (347 хоног) алба хаана.

Цэргийн алба хаасны дараа бэлтгэл хүчний бүртгэлд дараах байдлаар хамрагдана.

Үүнд:

- 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн. Цэргийн хугацаат алба хаасан иргэд 50 нас хүртлээ бэлтгэл үүрэгтэн байх бөгөөд 80, 150 хоногийн дайчилгааны цугларалт, сургалтад хамрагдах;
- 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн. Офицер болон ахлагч нар 60 нас хүртлээ бэлтгэл үүрэгтний бүртгэлд байх ба дээд тал нь 200 хоног давтан сургалтад хамрагдана гэж тус тус заажээ.

Сүүлийн 30 жилийн турш Финланд улсын Зэвсэгт хүчин геополитикийн нөхцөл байдалд Хүйтэн дайн дуусаагүй мэтээр хандаж, хуурай газрын томоохон зэвсэгт мөргөлдөөнд байнгын бэлтгэлтэй байсаар ирсэн тул Европтоо “хуучинсаг” хэв маягтай хэмээн тооцогддог байв. Нэг хүнд ноогдох хуурай замын зэвсэглэл, цэргийн бэлтгэлийн түвшингээр Европт тэргүүлэх хэмжээнд очсон байна. Сургалтын систем нь Батлан хамгаалах хүчний хувьсан өөрчлөгдөж буй шаардлага, хэрэгцээг хангахын тулд байнга судалгаатай хөгжиж байдаг. Хэдийгээр НАТО-д гишүүнээр элссэн ч “Финландыг хамгаалах үндсэн үүрэг Финландын өөрийнх нь байх болно” гэж үздэг. 2021 оны 5 дугаар сарын 18-нд Финландын БХЯ-наас явуулсан санал асуулгад оролцогчдын 82 хувь нь “тус

²⁴ 台湾兵役法 .2019.<https://law.moj.gov.tw/LawClass/LawAll.aspx?pcode=F0040002>

улс гаднын халдлагаас өөрийгөө хамгаалах чадвартай” гэж хариулсан нь иргэд цэргийн албандаа хэрхэн итгэлтэй байгааг харуулж байгаа юм. Цэргийн албаны тухай хуульд зааснаар алба хаахаас татгалзах, зугтах тохиолдолд 4 сараас доошгүй хугацаанд хорьж шийтгэх хуультай.

Япон: Японы өөрийгөө хамгаалах хүчин нь (ЯӨХХ) цэргийн албанд сайн дураар элсэн орж буй хүнийг эхлээд туршилтын хугацаагаар ажилд авна. Хуурай замын цэрэгт элсэгчид ихэвчлэн 2 жил (тусгай техникийн мэргэжлээр элсэхийг хүсч буй хүмүүс 3 жил) алба хаах гэрээ байгуулдаг. Тэнгисийн цэргийн болон Агаарын цэргийн албанд элсэгчид 3 жил хүртэлх хугацаагаар алба хаадаг байна. Сайн дурын үндсэн дээр алба хаах тогтолцоотой бөгөөд хугацаатай алба болон хугацаагүй буюу тэтгэвэрт гартлаа ажиллах алба гэж 2 хуваана. Цэрэгт элсүүлэх боломжтой 18-26 насны хүмүүсийн тоо 1990-ээд онд 17 сая байсан бол 2020 оны байдлаар 10 сая болж буурчээ. Иймд цэргийн албанд сайн дураар элсэх насны дээд хязгаар 26 байсныг 32 болгон нэмэгдүүлсэн. Бүс нутгийн болон дэлхийн аюулгүй байдлын нөхцөл байдал улам бүр хурцдаж байгаа үед Япон улс ойрын жилүүдэд цэргийн хүчин чадлаа нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Японы засгийн газар 2027 он гэхэд батлан хамгаалах зардлаа хоёр дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа зарласан нь боловсон хүчний тоог нэмэгдүүлэхтэй холбоотой юм. Гэсэн хэдий ч алба хаах боловсон хүчний дутагдалд ороод байгаа нь 2018-2019 онд Японы тэнгисийн цэргийн салбар элсүүлэх зорилтынхоо 60 хувийг ч биелүүлээгүй байгаа мэдээллээс харж болно.

Энэхүү цэрэгт элсэх хүмүүсийн тоо буурч байгаа нь ЯӨХХ-ний боловсон хүчний бодлогод том дарамт болж байна. Ирээдүйд боловсон хүчний илүү ноцтой хомсдолд өртөөд эхэлбэл ЯӨХХ нь батлан хамгаалах үүрэг, гамшгийг арилгах, энхийг сахиулах ажиллагааны оролцоонд сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн боловсон хүчний ихэнх хэсгийг технологитой ажиллах тусгай ур чадвар, мэдлэгтэй боловсон хүчнийг авахыг эрмэлзэж байна.

Ажиллах хүчний хомсдолын хажуугаар төрөлт буурч байгаа нь бас нэг том хүчин зүйл юм. 2019 онд Японы төрөлт анх удаа 900 мянгаас доош буусан нь 1899 онд статистик мэдээ гаргаснаас хойш хэзээ ч тохиолдож байгаагүй зүйл юм. Харин 2019 онд нас барсан хүний тоо 1,400,000-д хүрчээ. Цэрэгт элсүүлэх боломжтой 18-26 насны хүмүүсийн тоо 1990-ээд онд 17 сая байсан бол одоо ердөө 10 сая болж буурчээ. Иймд цэргийн албанд сайн дураар элсэх насны дээд хязгаар 26 байсныг 32 болгон нэмэгдүүлсэн.

2022 оны байдлаар ЯӨХХ-ний одоогийн зорилтот боловсон хүчний тоо 247,154 байхаас өнгөрсөн гуравдугаар сарын байдлаар 230,754 буюу энэ зорилтоос 16,400 хүнээр дутуу байна. Зэвсэгт хүчний дотроос хамгийн том нь болох хуурай замын өөрийгөө

хамгаалах хүчин хамгийн их өртөж, 11 мянга орчим боловсон хүчний дутагдалтай байна. Зарим нь бие бялдар, сэтгэл зүй, боловсролын стандартыг хангаагүйгээс болж энэ нөөц улам бүр багассан.

Өөр нэг гол хүчин зүйл бол Япон дахь ажилгүйдлийн түвшин харьцангуй бага байгаа нь ахлах сургууль, их дээд сургуулийн төгсөгчдөд ажлын байраа сонгохдоо илүү сонголттой байх боломжийг олгосон явдал юм. Одоо ЯӨХХ-нд алба хааж буй цэргүүдийн 8 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд цаашид энэ тоог нэмэгдүүлэх, албан хаагчдын заавал тэтгэвэрт гарах насыг цол тус бүрээр нэг жилээр хойшлуулах замаар боловсон хүчнээ тогтвортой байлгахыг эрмэлзэж байна.

Тэтгэвэрт гарсны дараа дахин ажилд орох эрхийг 65 нас хүртэл нэмэгдүүлсэн, дундаас доод түвшний боловсон хүчнийг элсүүлэх насны дээд хязгаарыг 36-аас 54 болгон нэмэгдүүлсэн байна.

Судалгааны ажлын хүрээнд нээлттэй эх сурвалжид тулгуурлан орнуудын хугацаат цэргийн албаны хугацааны өөрчлөлтийн талаарх дараах мэдээллийг нэгтгэн гаргав (Хүснэгт 3).

Хүснэгт 3.

Гадаадын зарим улс орнуудын хугацаат цэргийн албаны хугацааны өөрчлөлтийн талаарх судалгаа

Улс орнууд	Хугацаат цэргийн албаны хугацааны өөрчлөлт	Алба хаах хугацааг өөрчилсөн үндэслэл
БНХАУ	“Цэргийн албаны тухай хууль”-ийг баталж, 1978 оны 3 дугаар сард цэргийн алба хаах тогтолцоог хугацаат цэргийн алба хаагч, сайн дурын ажилтныг хослуулан болгон өөрчилсөн. 1984 оны 5 дугаар сарын 31-ний цэргийн жинхэнэ алба хаахыг сайн дурын алба болгон цэргийн албаны тогтолцоог хэрэгжүүлэхээр заасан байдаг. 1998 оны 12 дугаар сарын 29-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан “БНХАУ-ын Цэргийн албаны тухай хууль”-д цэргийн алба хааж байгаа цэргийг сайн дурын цэрэг, цэрэгжлийн нөөцийн албатай хослуулсан цэргийн алба хаах тогтолцоог хэрэгжүүлэхээр заасан. 2021 оны 8-р сарын 20-ны Ардын төлөөлөгчдийн XIII их хурлаар 18-22 насны эрэгтэй иргэнийг цэргийн жинхэнэ албанд, 18-22 насны эмэгтэй иргэнийг цэргийн хэрэгцээ, сайн дурын зарчмаар жинхэнэ албанд элсүүлж	- Дэлхийн болон бүс нутаг дахь их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхолтой уялдаж байна. - Бүс ба зам санаачилгын хүрээнд гадаад улс орнууд дахь улс төрийн бодлого эрчимжсэнтэй холбоотой.

	болно. Хугацаат цэргийн жинхэнэ алба хаах хугацаа 2 жил байна ²⁵ .	
Тайвань	1949 оны 12 дугаар сараас цэрэг татлагын тогтолцоог хэрэгжүүлж алба хаах хугацааг 1949-1987 онд армид 2 жил, тэнгисийн цэргийн болон нисэх хүчинд 3 жил тус тус тогтоосон. 1987-1990 оны 6 дугаар сар хүртэл арми, тэнгисийн цэрэг, агаарын хүчин 2 жил, хуурай замын цэрэг 3 жил алба хаах болсон. 1990 оны 7 дугаар сараас эхлэн бүх цэргийн алба 2 жил болсон. 2000 оны 1 сараас хугацаа нь 1 жил 10 сар болж, дараа нь жил ирэх тусам буурч 2008 оны 1 сар хүртэл 1 жил болж буурсан. 2013 оны 2 дугаар сараас 4 сарын цэргийн бэлтгэлд хамрагдаж, алба хаах ёстой гэж тогтоосон. 2022 онд 2005 оноос хойш төрсөн эрэгтэйчүүдийн цэргийн алба хаах хугацааг 1 жил болгон уртасгахаар болсноо зарласан байна.	- БНХАУ-ын Коммунист намын 20 дугаар их хурлаар анх удаа “Тайванийн тусгаар тогтнолыг эрс эсэргүүцнэ” гэж намын дүрэмд тусгасантай холбогдуулан үндэсний армийн хүч чадлыг өсөн нэмэгдүүлэх шаардлагатайг харуулсан. - Тайванийн 2022 оны 12 дугаар сарын 20-нд гаргасан олон нийтийн санал асуулгын дүнгээр нийт оролцогчдын 73.2% нь цэргийн албыг нэг жилээр сунгахыг зөвшөөрсөн байна.
ОХУ	• 1993 онд Цэргийн алба хаах хугацааг 1.5 жил, Тэнгисийн цэргийн хүчинд 2 жил болгон бууруулжээ. • 1996 онд Чечений кампанит ажлын улмаас шинэ хууль хүчин төгөлдөр болсон бөгөөд үүний дагуу арми, тэнгисийн цэргийн хүчинд үйлчлэх хугацаа 2 жил хүртэл байсан. • 2007 оны 1 сарын 1-нээс цэргийн алба хаах хугацааг 18 сар болгосон байна.	
Норвеги	2014 оноос хойш хүйсийн адил тэгш эрхтэйгээр цэргийн албыг 12-19 сарын хугацаатай хаадаг болсон ²⁶ .	12-19 сар нь Норвеги улсыг гадна хүчнээс хамгаалахын тулд шаардлагатай бүх зүйлсийг сурч мэдэх сургалтын хугацаанд тулгуурлан гаргасан хугацаа гэж үздэг.
Вьетнам	1975 оноос эхлэлтэй бөгөөд 18-25 насны бүх эрэгтэйчүүдийг цэргийн албыг заавал хаахыг шаарддаг. 1990 оноос цэргийн албыг 3 жил хаадаг байсныг бууруулж 2 жил болгосон байдаг.	• нэгдүгээрт улсын аюулгүй байдлын нөхцөл буурсан, • хоёрдугаарт эдийн засгийн нөхцөл байдал, батлан хамгаалах салбарт зарцуулах төсвийг хэмнэх,

²⁵ 中华人民共和国兵役法. http://www.mod.gov.cn/regulatory/2021-08/20/content_4892491.htm

²⁶ <https://thenorwayguide.com/military-conscription/#:~:text=Norway%20has%20a%20mandatory%20military,months%20for%20unpaid%20military%20service.>

		• гуравдугаарт хагас цэрэгжүүлсэн, нөөц хүчний бүрэлдэхүүнийг хямд зардал төсвөөр бэлтгэх болсонтой холбоотой.
--	--	--

Дүгнэлт:

Дээр судлагдсан гадаад орны туршлагаас харахад ихэнхдээ улс орнуудын гадаад аюулгүй байдлын орчны нөхцөл, тухайн улсын эдийн засгийн хүчин чадлаас хамаарч хугацаат цэргийн албаны бодлого тодорхойлогдож байна. Тухайлбал, цэргийн албыг биеэр, дүйцүүлэх гэх мэтээр хаахаас гадна тусгай мэргэжлийн, мэргэжлийн зэрэг ур чадварт үндэслэн алба хаах хугацааг харилцан адилгүй тогтоож байна.

Скандиновын орнуудаас бусад улс оронд хугацаат цэргийн албыг хаах хүсэл эрмэлзэл бага байдаг учраас улс орнуудад ажлын байр, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг нь дэмжих зэрэг урамшууллын бодлогоор иргэдээр цэргийн алба хаалгах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн бие бялдар эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанд тэнцээгүй цэргийн насны эрэгтэйчүүдэд их дээд сургуулийн хөтөлбөрийн хүрээнд цэргийн хэргийн мэдлэг олгож мэргэжил, боловсрол, чадварыг нь харгалзан холбогдох нөөц хүчинд бүртгэх, иргэний нийгмийн ажилд идэвхтэй оролцуулах зэргээр албыг хаалгадаг байна.

Дээрх улс орнуудад эмэгтэйчүүд цэргийн алба хаах шаардлагагүй ч сайн дураараа цэргийн алба хааж болохоор тусгасан нь цэргийн алба хаагчдын тоог өсгөх, албанд хандах эерэг нөлөөг бий болгож байна.

Зарим улс оронд тухайн улс орны аюулгүй байдал тухайлбал байгалийн гамшиг, халдварт өвчин эмгэгтэй тэмцэх, аврах, сэргээн босгох ажиллагааны үед болон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах байгууллагад ажилласан бол цэргийн албанаас чөлөөлөх, эсвэл хугацааг багасгах үндэслэл болж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.
МОНГОЛ УЛСЫН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААХ ӨНӨӨГИЙН
ТОГТОЛЦОО, СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН АГУУЛГАД
ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хугацаат цэргийн алба хаах тогтолцооны талаар

Манай улс 1925 оноос эхлэн иргэдээр Хугацаат цэргийн алба хаалгахтай холбоо бүхий шийдвэрийг 10 удаа гаргасан бөгөөд алба хаах хугацааг 6 удаа өөрчилсөн байна. 1926 онд Хувьсгалт цэргийг бэхжүүлэх зорилгоор алба хаах 2 жилийн хугацаат цэргийн албыг 1 жил болгосон. 1929 онд зэвсэглэл, техникийн хөгжилтэй холбоотойгоор бага дарга, цэргүүдийн алба хаах хугацааг 2 жил, харин техникийн цэргийг 3 жил болгон дахин өөрчилсөн. 1930 онд Дотоод, гадаад улс төрийн нөхцөл байдал түгшүүртэй болсонтой холбоотойгоор алба хаах хугацааг 5 жил болгосон байдаг. Гэхдээ энэ 5 жилийн эхний жилд 4 сар, дараагийн 4 жилд тус бүр 2 сараар алба хаах, өөрөөр хэлбэл 5 жилийн туршид богино хугацаа (2-4 сар)-гаар нийтдээ 1 жил алба хаах уян хатан хэлбэрийг бий болгож байжээ.

1935 онд Улс орны гадаад нөхцөл, олон улсын цэрэг улс төрийн байдалтай уялдуулан алба хаах хугацааг 3 жил болгосон ба энэ хугацааг хэвээр хадгалах тухай шийдвэрүүдийг 1944, 1949 онуудад гаргасан байна. 1985 онд олон улсын байдалд эерэг өөрчлөлт гарсантай уялдуулан хугацаат цэргийн албыг 2 жил хаах /дээд боловсролтой хүмүүс 1 жил/ болгосон. Улс орны улс төрийн тогтолцоонд өөрчлөлт орж, батлан хамгаалах төсвийг багасган, Зэвсэгт хүчнийг цомхон, чадварлаг болгох тухай шийдвэр гарснаар 1992 оноос хугацаат цэргийн албыг 1 жил болгосон ба өнөөг хүртэл энэ хугацааг мөрдөж байна.

Монгол Улсын иргэн “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт заасны дагуу цэргийн алба хаах үүрэгтэй. Хугацаат цэргийн албыг нэг жилийн хугацаагаар хаах өнөөгийн тогтолцоо нь 1992 оноос эхэлсэн. Тухайн үед “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулиар 18-25 насны залуучуудыг хугацаат цэргийн албанд татах, халах ажиллагааг жилд 2 удаа 5, 10 дугаар саруудад зохион байгуулан хугацаат цэргийн албыг хаалгадаг тогтолцоотой байсан.

“Цэргийн албаны тухай” хуулийг 2016 онд баталснаар өнөөгийн тогтолцооны дагуу 18-27 насны залуучуудыг хугацаат цэргийн албанд татах, халах ажиллагааг жилд 1 удаа зохион байгуулан явуулж байна. 2016 онд баталсан “Монгол Улсын батлан хамгаалах

тухай” хуулиар батлан хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлж, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх үүрэгтэй холбогдсон харилцааг нарийн зохицуулж өгсөн байдаг. Тус хуулийн 19 дүгээр зүйлд Монгол улсын иргэн эх орноо хамгаалах бэлтгэлтэй байх, мөн хуулиар тогтоосон иргэний цэргийн алба хаах үүргээ биелүүлэх үүрэгтэйг хуульчилсан байдаг.

Түүнчлэн 2015 онд Монгол Улсын Их Хурлын 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан Хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж”, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно. Цэргийн албыг биеэр болон хуульд заасан хэлбэрээр хаагаагүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Цэргийн алба хаагчийн ажил үүргээ гүйцэтгэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нийгмийн чиглэлүүдийг тусгаж өгсөн байдаг.

Мөн Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд Иргэний цэргийн үүргийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Монгол Улсын иргэн цэргийн албанд татагдах, элсэх, цэргийн мэргэжил эзэмших, цэргийн байгууллагад цэргийн алба хаах, үүрэг гүйцэтгэх, цэргийн бэлтгэл үүрэгтэнээр цэргийн бүртгэлд байх, цэргийн дайчилгааны цугларалт сургуульд оролцох нь цэргийн үүрэгт хамаарна.

2. Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.

3. Дайны байдлын үед иргэний цэргийн үүргийг Монгол Улсын Үндсэн хууль холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

4. Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана.

Хугацаат цэргийн алба хаах өнөөгийн тогтолцоо:

- Хугацаат цэргийн алба /12 сарын хугацаатай/
- Цэргийн сургуулийн оюутан /суралцах хугацаанд 3 улирлын хугацаатай/
- Оюутан цэрэг /1 дүгээр дамжааны оюутан 4 сарын хугацаатай/.

Бусад хэлбэр:

Цэргийн дүйцүүлэх албаны хэлбэрүүд

- Нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн /Цагдаа, Тагнуул, ШШГА, ШША-нд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр 2-оос дээш жил алба хаасан төрийн тусгай алба хаагчийг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцно.
- Хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн /шашин шүтлэг, ёс зүйн шалтгаанаар 18-25 насны иргэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн 24 сарын хугацаатай/ хааж болно.
- Хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн /алслагдсан сум, сум дундын сургууль, эмнэлэгт багш, эмчээр 3 жилээс дээш ажилласан иргэнийг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцно.
- Иргэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах гэсэн хэлбэрүүдээр цэргийн алба тус тус хааж байна.

Улсын хэмжээнд хугацаат цэргийн алба хаах насны ангилалд багтаж байгаа нийт иргэдийн 2.9 хувь нь Зэвсэгт хүчин, Хилийн болон Дотоодын цэрэгт цэргийн жинхэнэ алба хааж байна. Харин “оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах замаар цэргийн алба хааж байгаа иргэд 0.5-0.6 хувь, Цэргийн сургуулийн оюутан болон бусад их дээд сургуульд цэргийн тусгай хөтөлбөрийн дагуу сургалт бэлтгэлд хамрагдсан оюутнууд 0.1 хувийг эзэлж байгаа бол Цэргийн дүйцүүлэх албаны хэлбэрүүдээр нийт иргэдийн 4.1-4.4 хувь нь цэргийн албыг хааж байна. Өөрөөр хэлбэл манай улсын хугацаат цэргийн алба хаах насны нийт иргэдийн дөнгөж 8 орчим хувь нь аль нэг хэлбэрээр цэргийн алба хааж байгаа дүн гарч байна.

Хугацаат цэргийн албаны давуу талууд:

1. Улсад

- Батлан хамгаалах эрх ашиг хангагдана;
- Хороо, бригадын түвшний байлдааны жигдрэлтийн сургууль явуулах боломж бүрдэнэ;
- Нэгтгэл, анги, салбаруудын тайван цагийн орон тоогоор байлдааны үүрэг гүйцэтгэх боломж нэмэгдэнэ;
- Цэргийн нарийн мэргэжлийн дайчилгааны бэлтгэл нөөц нэмэгдэнэ;
- Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох хүний нөөцийн хангалт сайжирна.

2. Иргэнд

- Ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь иргэнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангах;
- Алба хаасан хугацааг хөдөлмөрийн хуулиараа иргэний ажилласан жилд оруулж тооцох;

- Төрийн албанд ажиллах сонирхолтой иргэд /Төрийн албаны тухай хуулийн 22.1.6-т “хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх/;

- Алба хаах хугацаанд их дээд сургууль, МСҮТ-д, суралцаж энгийн мэргэжил эзэмших боломжоор хангагдах;

- Бүтээн байгуулалтын ажилд оролцож, нэмэгдэл цалин хөлс авах;

- Төрийн тусгай албанд ажиллах;

- Эх орноо батлан хамгаалах цэргийн мэргэжил эзэмших, нийгэмд эзлэх байр суурь өснө.

Сул талууд:

- Өнөөгийн тогтолцоогоор дайчилгааны бэлтгэл нөөцийг сургаж, бэлтгэх нөөц бүрдүүлэхэд их хугацаа шаардана;

- Жил тутам цэргийн насанд хүрч байгаа залуусын зөвхөн 2.6-2.7 хувь нь алба хааж байна;

- Цэргийн насны залуусын өвчлөл их байна;

- Ажиллах хүчний тоонд сөргөөр нөлөөлнө;

- Хугацаат цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэх төсөв хангалтгүй;

- Цэргийн албаны талаар ард иргэдийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байгаа асуудал их байна.

Цэргийн алба хаахаас татгалзаж буй нийтлэг шалтгаанууд:

- Албан бус хөдөлмөр хийлгэх;

- Алба хаах орчин нөхцөл тааруу;

- Цалин хангамж бага;

- Хугацаа урт;

- Цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэж байгаа бүрэлдэхүүний мэдлэг боловсрол харилцаа, хандлага ёс зүй хангалтгүй;

- Эзэмшиж буй зэвсэг техник хуучирсан.

Бусад шалтгаанууд:

- Улсын болон хувийн их дээд сургуульд суралцах;

- Гадаадын улс оронд ажиллах, суралцах;

- Цэргийн албыг дүйцүүлэн мөнгөн төлбөрөөр хаах;

- Цэргийн зарлан дуудах хуудас аваад очихгүй байх;

- Торгуулийн мөнгөн төлбөрийг төлөх;

- Шилжилт хөдөлгөөн хийх, оршин суугаа газар тодорхойгүй байх;

- Ар гэрийн болон эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөх хуурамч баримт бичиг бүрдүүлэх;
- Эрх бүхий албан тушаалтан ах дүү, хамаатан садан, найз нөхдөд нөлөөлөх;
- Нийслэл, аймаг, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, орон нутгийн болон цэргийн эмнэлгийн эмч нарын дүгнэлтээр чөлөөлөгдөх гэх мэт.

Монгол Улсын Их Хурлын 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж”, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно. Цэргийн албыг биеэр болон хуульд заасан хэлбэрээр хаагаагүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Цэргийн алба хаагчийн алба хаах орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нийгмийн чиглэлүүдийн дагуу хууль эрх зүйн шинэчлэлтээр алба хаах хэлбэрүүдийг өөрчлөх, нэмэгдүүлэх (олон хувилбартай), хэлбэр тус бүрд тохирсон нөхцөл, хугацаа, сургалтын онцлогийг журамлах, нэгтгэл, ангиудын цэргийн байр, сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх, орчин үеийн цэргийн сургалт бэлтгэлд ашиглаж буй дэвшилтэт, тоног төхөөрөмжийг ашиглах олон улсын жишигт нийцсэн сургалтын төвүүдийг нэмэгдүүлэх, төхөөрөмжлөх шаардлага тулгарч байна.

Хугацаат цэргийн албыг чанаржуулахын тулд:

- Хууль эрх зүйн шинэчлэлтээр алба хаах хэлбэрүүдийг өөрчлөх, нэмэгдүүлэх (олон хувилбартай болгох);
 - Хэлбэр тус бүрд тохирсон нөхцөл, хугацаа, сургалтын онцлогийг журамлах;
 - Нэгтгэл, ангиудын цэргийн байр, сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх;
 - Сургалтын төвүүдийг нэмэгдүүлэх, төхөөрөмжлөх;
 - Хугацаат цэргийн алба хаагч (ХЦАХ)-дыг зөвхөн хэрэгтэй зүйлд нь сургах. (Англи хэл, Монгол бичиг, Хүний эрхийн сургалт, Төрийн албаны бэлтгэл гэх мэт олон төрлийн сургалтуудыг зохион байгуулах чиг үүрэг БХЯ-аар дамжуулан ирдэг. Шаардлагатай сургалтын агуулгыг хөтөлбөрт нь оруулах байдлаар зохицуулж болно);
 - Нэгтгэл, анги, салбаруудын сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх. ХЦАХ зарим сургалтыг бие дааж сурдаг, цэрэг нэг бүрийн болон эзэмшиж буй мэргэжлийн чиглэлээр гүнзгийрүүлэн судлах материалыг олшруулах, төрөл бүрийн хотхон, талбай, дадлагын төхөөрөмжийг нэмэгдүүлэх, байгуулах;
 - Хугацаат цэргийн албыг 2 ээлж болгосноор сургуулийн салбар, сургууль-байлдааны салбарын сургалт үр дүнтэй явагдах, байнгын бүрэлдэхүүний сургалт тасалдахгүй байх зэрэг давуу талтай;

- ХЦАХ-дын сургалтын хэрэглэгдэхүүнийг өөрчлөх. Тухайлбал хугацаат цэргийн алба хаагчийн сургалтын материалыг бэлнээр хэвлэж хангах, халагдахдаа авч явдаг байх (“Оролцоо” төслийн сургалтын материалын загвараар хийж болно).

Хугацаат цэргийн албаны эдийн засгийн тооцоо

Өнөөдрийн байдлаар цэргийн алба хаах хугацаа 12 сар байгаа бөгөөд нэг цэргийн албан хаагчид сард 583,333 төгрөг зарцуулдаг ба 12 сард үржүүлбэл жилдээ 7 сая орчим төгрөг болж байгаа ба үүнийгээ 3000 орчим цэргийн албан хаагчдад зарцуулбал 21 тэрбум орчим төгрөг болж байгааг доор хүснэгтээс харж болно.

Хэрэв хугацаат цэргийн албыг 6 сар болгож 3000 хүнд зарцуулж буй 21 тэрбум төгрөгөөрөө 6100 орчим хүнийг буюу нэмэлтээр 3100 хүнээр илүү татан авч сургаж болохыг хүснэгтийн 1 дүгээр мөрөөр харууллаа.

№	Хугацаа	Нэг цэргийн албан хаагчид ногдох зардал нэг сараар	Нэг цэргийн албан хаагчид ногдох зардал	Цэргийн албан хаагчдын тоо	Нийт
1.	6 сар	583,333	3,499,998	6100	21,349,987,800
2.	8 сар	583,333	4,233,928	3000	12,701,784,000
3.	12 сар	583,333	7,000,000	3000	21,000,000,000
4.	18 сар	583,333	10,499,994	3000	31,499,982,000
5.	24 сар	583,333	13,999,992	3000	41,999,976,000

Хугацаат цэргийн албаны сургалт бэлтгэлийн өнөөгийн байдал:

Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийг ЗХЖШ-ын даргын 2021 оны А/630 дугаар тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн бодлого”, 2022 оны А/579 дүгээр тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам”, түүнд нийцүүлэн боловсруулсан төрлийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах заавруудын хүрээнд зохион байгуулж байна.

“Цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн тогтолцоо” нь цэргийн сургалт бэлтгэл нэгдсэн бодлого, төлөвлөлт, харилцан уялдаатайгаар зохион байгуулах төрлийн цэргийн сургалтын дэд тогтолцооноос бүрдэнэ²⁷ гэж тодорхойлсон. Иймээс төрлийн цэргийн командлал, удирдах газраас төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, харьяа нэгтгэл, ангийн гүйцэтгэх үүргийн онцлогт нийцсэн цэргийн сургалт бэлтгэлийг бие даасан байдлаар, цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журамд нийцүүлэн зохион байгуулна.

²⁷ “Цэргийн сургалт бэлтгэлийн бодлого” баримт бичгийн 3 дугаар зүйлийн 3.1. дэх заалт;

Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчний хэмжээнд 24 нэгтгэл, ангид жил бүр 100-300 хүртэл, нийт 3000 орчим ХЦАХ-ийг 70 орчим мэргэжлээр бэлтгэж байна.

ХЦАХ-тай нэгтгэл, ангиуд:

1. ЗХЖШ-ын харьяа ангиуд (032, 013, 311, 015, 232)
2. Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиуд (016, 014, 119, 120, 123, 167, 186, 256, 326, 327, 336)
3. БИЦУГ-ын харьяа ангиуд (017, 110, 338, 339, 340, 341, 342)
4. ҮБХИС (029) зэрэг болно.

Хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт бэлтгэлийн зохион байгуулалтын онцлог.

ХЦАХ-дын цэргийн сургалт бэлтгэл нь **“цэргийн мэргэжил олгох”**, болон **“мэргэшүүлэх”** сургалтаас бүрдэнэ.

“Цэргийн мэргэжил олгох сургалт”-ыг “хүн нэг бүрийн бэлтгэл” шатанд дараах сургалтаар зохион байгуулна. Үүнд:

- “цэргийн албанд дасгах сургалт”,
- “цэргийн анхан шатны бэлтгэл”
- “цэргийн ерөнхий бэлтгэл”-ээр зохион байгуулна.

“Мэргэшүүлэх” сургалтыг “салбарын жигдрэлт”-ийн болон “бататгах”, “бэлэн байдлыг хангах” шатуудад албан тушаалд нь томилогдсон, салбар, нэгжийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгүүлэх замаар зохион байгуулна.

ХЦАХ-дын сургалтыг “мэргэжлийн суурь” болон “мэргэшүүлэх” хичээлүүдээр зохион байгуулна.

“Мэргэжлийн суурь хичээл” гэж бие бүрэлдэхүүний цэргийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай цэргийн хэргийн мэдлэг, дадлага эзэмшүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх зорилготой багц хичээлийг²⁸ хэлэх ба өнөөдрийн байдлаар “Цэрэг-эх оронч хүмүүжил”, “Талын бэлтгэл”, “Биеийн тамирын бэлтгэл”, “Цэргийн дүрмүүд”, “Жагсаалын бэлтгэл”, “Сэтгэл зүйн бэлтгэл” хичээлүүдээр зохион байгуулагдаж байна.

“Мэргэшүүлэх хичээл” гэж бие бүрэлдэхүүнд тайван болон дайны цагт албан тушаалын үүргээ мадаггүй биелүүлэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, дадлага, ур

²⁸ “Цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4.5 дахь хэсэг

чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн цэргийн төрөл, тусгай мэргэжлийн хичээлийг хэлэх²⁹ ба үүнд “Тактик, тусгай тактик”, “Мэргэжлийн бэлтгэл” хичээлийг тус тус судалж байна.

Мэргэшүүлэх болон мэргэжлийн суурь хичээлүүдийн нэр, төрөл, агуулгыг “Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын стандарт” (2008 он)-аар тогтоож, жил бүр “Сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах заавар”-аар нэмэлт тодотголыг хийдэг.

Зарим жилүүдэд ХЦАХ-дын мэргэжлийн суурь сургалтын хөтөлбөрт “Монгол бичиг”, “Англи хэл”, “Хүний эрхийн сургалт”, “Төрийн албаны бэлтгэл” болон бусад сургалтуудыг оруулах үүрэг, чиглэлийг холбогдох яамд, төрийн байгууллагаас БХЯ-аар дамжуулан оруулж ирсэн.

ХЦАХ-дын сургалтын нийт цагийг төрлийн цэргийн командлал, удирдах газраас өөр өөрөөр тогтоож байгаа бөгөөд дунджаар 6-7 мэргэжлийн суурь хичээлд 160-180 цаг, мэргэшүүлэх сургалтын “тактик-тусгай тактик”-ийн хичээлд 180-200 цаг, “мэргэжлийн бэлтгэл” хичээлд 140-160 цаг, нийт 480-540 цагийг төлөвлөж байгаагаас мотобуудлагын нэгтгэл, ангид сургалтын цаг илүүтэй ноогдож байна.

Мөн нийт хичээлийн цагийн 30 орчим хувь нь “мэргэжлийн суурь” хичээлүүдийнх бол 70 орчим хувь нь “мэргэшүүлэх” хичээлийнх бөгөөд 30 хүртэл хувь нь онолоор, 70 хүртэл хувь нь дадлагаар зохион байгуулагдаж байна.

ХЦАХ-дыг бүтээн байгуулалтын болон аж ахуйн ажилд дайчлан оролцуулах, цэрэгжлийн спортын уралдаан, тэмцээнүүдэд бэлтгэж, оролцуулах зэргээс шалтгаалж бодит байдалд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 50-60 хувьтай байна. Сургуулийн жилийн II үед хураангуй салбар, нэгжийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх, ажлын байран дээрх дадлагыг нэмэлт сургалтаар зохион байгуулж байна.

Нэмэлт сургалтыг төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангиудаас ХЦАХ-дыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах, алба хаасны дараах ажил, хөдөлмөрийн баримжаа олгож, иргэний мэргэжилд сургах зорилгоор зохион байгуулдаг. Тухайлбал:

- Барилга-инженерийн цэргийн ангиуд дотооддоо болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран барилгын өргөн мэргэжлийн чиглэлээр;

- Бусад нэгтгэл, ангиуд орон нутаг дахь боловсролын байгууллага, ихэвчлэн МСҮТ-өөр дамжуулан барилгын өргөн мэргэжил, жолооч болон бусад мэргэжлээр сайн дурын үндсэн дээр сургаж бэлтгэдэг.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд жилд орон нутгийн их, дээд сургууль, МСҮТ, иргэний боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж жилд 20 гаруй төрлийн

²⁹ “Цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4.5 дахь хэсэг

мэргэжлээр 500 орчим ХЦАХ-дыг богино хугацааны сургалтад хамруулдаг байсан туршлага бий. Тухайлбал 2019 онд Говьсүмбэр аймаг дахь Политехникийн коллеж, Налайх дүүрэг дэх МСҮТ, Зэвсэгт хүчний 336 дугаар ангид Хүнд машин механизмын оператор /118/, Хүнд машин механизмын засварчин /10/, Гагнуурчин /15/, Тогооч /16/, Авто зам гүүр угсралтын ажилтан /28/ мэргэжлээр Зэвсэгт хүчний 15 анги, байгууллагын 187 ЦАХ-дыг 2 шаттайгаар сургаж бэлтгэсэн бол 2021 онд МСҮТ-үүдтэй хамтран 10 ангид, 12 мэргэжлээр 176, 2022 онд 4 анги МСҮТ-тэй хамтран 211 ХЦАХ-ийг барилгын мэргэжлээр буюу 14 мэргэжлээр сургаж бэлтгэсэн. Гэхдээ “Ковид” цар тахлын улмаас энэ арга хэмжээ тасарч, цэргийн алба хаагчдад давхар иргэний мэргжил олгох арга хэмжээ зогсонги байдалд орсон.

Дүгнэлт:

Зэвсэгт хүчний ХЦАХ-дын сургалтын “анхан шатны бэлтгэл”-ийг нэгдсэн журмаар ЗХЖШ-аас, бусад сургалтыг төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангийн шийдвэрээр зохион байгуулж байна.

“Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог төрлийн цэргийн сургалтын дэд тогтолцооноос бүрдэнэ” гэж заасан нь ХЦАХ-дын сургалт бэлтгэл орхигдох, төрлийн цэргийн нэгтгэл, ангиудад нэгдсэн бус стандартаар явагдах болсон нь зарим талаар учир дутагдалтай байна.

ХЦАХ-дад сургуулийн жилд 500 гаруй цагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөдөг боловч цэрэгжлийн спортын уралдаан, тэмцээн, бүтээн байгуулалтын болон аж ахуйн ажилд оролцуулдгаас сургалт 50-60 орчим хувийн хэрэгжилттэй явагдаж, үлдсэн хувь нь цаасан дээр төлөвлөлт хэлбэрээр үлдэж байна.

ХЦАХ-дын бичиг хэргийн зардлыг сургуулийн жил бүр шинэчлэн тогтоодог бөгөөд өнөөдрийн байдлаар 75 орчим мянган төгрөгийн 16 нэр төрлийн хэрэглэгдэхүүнийг худалдан авч хангаж байгаа хэдий ч цаг үеийн болоод чанарын шаардлага хангадаггүй. Мөн нэгтгэл, ангиудаас цэрэг нэг бүрт зарцуулж буй сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг бүрэн тооцдоггүй, сум, галт хэрэглэл зэрэг зарим хэрэглэгдэхүүнийг бүрэн зарцуулдаггүй зэрэг дутагдал гарч байна.

Мөн хугацаат цэргийг жилд 1 ээлжээр татдаг болсны улмаас тэдний анхан шатны болон ерөнхий бэлтгэлийн сургалтын хөтөлбөрийг хангатай байнгын бие бүрэлдэхүүн харуул, хоногийн манааны болон бусад үүргийг нь хариуцан гүйцэтгэх болсноор анги байгууллагын бэлэн байдалд хүндрэл учирч, байнгын бүрэлдэхүүний сургалт бэлтгэл тасалдах болсон. Ингэснээр “мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин”-ийг бэлтгэх “үндсэн сургалт” болон “байнгын бүрэлдэхүүний сургалт” тасалдах болсон.

ХЦАХ-дыг сургаж бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагын хотхон, дутмаг, багаж, тоног төхөөрөмж хангалтгүй, дуурайлган үзүүлэх хэрэгсэл хангалтгүй, симуляцын тоног төхөөрөмж байхгүй байна.

Мөн ХЦАХ-тай явуулж буй сургалтын агуулга, төлөвлөлт, зохион байгуулалтын арга барил хоцрогдсон, даргалах албан тушаалтнуудын заах арга зүй дутмаг, аюул эрсдэлээс сэргийлэх нэрийдлээр бодит цагийн байдалд ойлгосон дадлага, сургалтыг бага явуулдаг, салаа, салбараас бие дааж цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах эрх, боломж хязгаарлагдмал, анги байгууллагын засвар, тохижилт, тариа ногоо хураах зэрэг аж ахуйн ажлын улмаас сургалтыг орхигдуулах явдал гардаг. Бүтээн байгуулалтын болон хадлан, ургац хураалтын ажил нь тогтсон хугацаатай төдийгүй тодорхой тооны хугацаат цэргийн алба хаагчид хамрагддаг. Энэ бүхний улмаас нэгтгэл, анги, салбар дахь төлөвлөгөөт сургалтын цагийн нэлээд хэсэг тасарч байна.

Түүнчлэн жилд нэг удаа цэрэг татдаг болсноор ХЦАХ-дын идэвхтэй сургалт өвөл, хаврын улиралд явагдах болсноор дадлагын хичээлд оногдох хугацаа багасч цэргийн сургалт бэлтгэлийн үр дүнд сөргөөр нөлөөлөх хандлага байна.

Хугацаат цэргийн алба хаах хэлбэр, хугацааны талаарх зарим судалгааны дүнгээс харахад алба хаах хугацааг багасгах (3-6 сар болгох) санал хамгийн их байдаг ч ийм саналыг ихэнхдээ цэргийн албыг биеэр хаагаагүй залуус өгсөн байдаг. Хугацаат цэргийн албыг 24, 36 сар болгох санал 3 дугаарт эрэмбэлэгддэг хэдий ч санал өгсөн хүмүүс нь ихэвчлэн 2, 3 жилийн алба хаасан ахимаг насныхан байдаг. Харин хамгийн бодит тоо буюу 2 дугаар эрэмбэлэгддэг 12 сар алба хаах хугацааг дэмжсэн саналыг цэргийн албыг биеэрээ хаасан залуус голчлон өгч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хугацаат цэргийн албаны “сургалт бэлтгэлийн стандарт, хөтөлбөр”-ийг биеэр болон дүйцүүлэх хэлбэрээр адилтган хаалгах хувилбар

Хугацаат цэргийн алба хаагчдын 1 жил буюу 12 сарын сургалтын хөтөлбөрийг бусад дүйцүүлэх албаны сургалт бэлтгэлтэй уялдуулж болно.

Энэ нь ХЦАХ-дын сургалт бэлтгэлийг 1 жил, 6 сар, 3 сараар үечилж зохион байгуулснаар хангагдана. Тухайлбал:

- Хугацаат цэргийн албаны “хагас жил”-ийн сургалтын хөтөлбөрийг кредит цагт шилжүүлэн “дүйцүүлэх алба” хааж буй иргэдэд эхний 3 сард цахимаар болон бие дааж суралцах материал, судлах зүйлийг олгож, дараагийн 3 сарын хугацаанд нь “биеэр хаах”-аар зохион байгуулна.

- ХЦАХ-дын судлах зүйл, сургалтын хэрэглэгдэхүүнийг цаашид “Оюутан цэрэг”, “Оролцоо” төслийн хүрээнд хийгдсэн багш, суралцагчийн гарын авлагын загвараар хийх, зарим зардлыг өөрсдөөс нь гаргуулан шийдвэрлэж болно.

Хугацаат цэргийн алба хаах дараах хэлбэрүүд, тэдгээрт тохирсон сургалтын аргууд байж болно гэж үзэж байна. Үүнд:

- Хугацаат цэргийн албыг “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт заасны дагуу **“... хуулийн дагуу цэргийн алба хаах” үндсэн үүрэг**, “Цэргийн албаны тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. дэх заалтын дагуу **“Хугацаат цэргийн алба хаах хугацаа 12 сар байна”** гэсэн үндсэн хугацааны заалтуудыг үндэслэл болгон алба хаах хэлбэрүүдийг нэмэгдүүлж, тухай бүрд тохирсон хугацаа, сургалтыг зохион байгуулж болно. Тухайлбал:

о **“Цэргийн албыг биеэр хаах”** - Хугацаат цэргийн албаны үндсэн хэлбэр бөгөөд биеэр алба хаах хугацаа 12 сар. Жилд 2 ээлжийн татлагаар Барилга-инженерийн цэргийнхээс бусад нэгтгэл, анги, салбарт алба хаана.

о **“Гэрээт цэрэг”** - Хугацаат цэргийн албанд 3-6 сарын хугацаатай “анхан шат”-ны болон “ерөнхий бэлтгэлийн шат”-нд хамрагдаж, “цэргийн мэргэжил эзэмших”, үүний дараа 3-6 хүртэлх сарын хугацаанд “иргэний мэргэжил” эзэмшиж, гол төлөв Барилга-Инженерийн цэрэгт цаашид 12-24 хүртэл сарын хугацаатай “гэрээ” байгуулж, Зэвсэгт хүчинд алба хаахын зэрэгцээ бүтээн байгуулалтын ажилд оролцож, мэргэжилтэй, цалинтай, орлоготой болох боломжийг бүрдүүлсэн. Гэрээгээр алба хаах хугацааг 1-2 удаа сунгах боломжтой байна.

о **“Цэргийн сургуулийн оюутан”** - “Оюутан цэрэг”-ийн хувилбартай төстэй боловч цуглуулах кредитийн тоо их, офицер, ахлагчийн албан тушаалд дадлагажиж, цэргийн бэлтгэл үүрэгтэн болно. Тасаг, салаа, салбарын жигдрэлтэд хамрагдаж, албан тушаалд дадлагажна.

о **“Оюутан цэрэг”** - I дамжаанд сургуулийнхаа мэргэжлийн танхим, сургалтын хөтөлбөрүүдээр онол, дадлагын сургалтад хамрагдаж, бие даан кредит цаг цуглуулна. II дамжаанд бие даалтын хажуугаар 3 сарын хугацаатай биеэр хаах албанд суралцаж, ХЦАХ-дын “мэргэжил олгох” болон “мэргэшүүлэх” хөтөлбөрийг хангана. Зөвхөн алслагдсан бүс, сумдын биш бүх эмч, багш нар ч биеэр алба хааж цэргийн мэргэжил эзэмшиж, бэлтгэл үүрэгтэн болно. (офицер, ахлагч)

о **“Биеэр дүйцүүлэх алба - 1”** - Оюутан цэргийн хувилбартай төсөөтэй хэдий ч цуглуулах кредит, ялангуяа дадлагын цаг бага, нийт үргэлжлэх хугацаа 2 жил, хамрагдах насны дээд хязгаар, ажлынхаа хажуугаар ижил зарчмаар явагддаг. Насны дээд хязгаар нь 30 хүртэл ба сургалт жилийн хугацаанд тасалдахгүй байх.

- **“Биеэр дүйцүүлэх алба - 2”** - Дайчилгааны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 5 жил тутамд эсхүл нэг удаа 3 сарын хугацаанд биеэр хаалгах хуулийг санаачлан хэрэгжүүлэх. “Дүйцүүлэх алба”-ны биеэр хаах 3 сарын сургалтыг Зэвсэгт хүчний

сургалтын нэгдсэн төв, Хужирбулан дахь Сургалтын төв, Шар хадны сургалтын төв, Хуурай замын цэргийн сургалтын төв (Төв-Алтанбулаг-119, Өмнөговь-Даланзадгад-167), Тусгай хүчний сургалтын төвүүдэд 1 удаад 1000 хүртэлх хугацаат цэргийг татаж хаалгах боломжтой.

О Хуульд заасан бусад хэлбэр. Мөнгөн төлбөрийг орлуулахаас бусад дүйцүүлэх албаны хэлбэр байж болно. Сайн дурын үндсэн дээр эмэгтэй цэргийн алба хаагчдыг 3 сарын хугацаанд бэлтгэж болно.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
(2 ээлжээр хаах санал)

Хүснэгт №5.

		Үндсэн сургалтын буюу нэгдүгээр үе					Бататгах сургалтын буюу хоёрдугаар үе			
Хугацаа	I ээлж	X.15-XI.30		XII.01-I.15	I.16-III.31			IV.01-VII.31	VII.31-X.14	
	II ээлж	IV.15-V.31		VI.01-VII.15	VII.16-IX.30			XII.01-I.15	I.16-III.31	
Төрөл		(3 сарын сургалт)			(3 сарын сургалт)			(3 сарын сургалт)	(3 сарын сургалт)	
		Цэргийн мэргэжил олгох сургалт			Мэргэшүүлэх сургалт					
Зохион байгуулалт (хүн нэг бүрийн бэлтгэл, салбарын жигдрэлт, нэмэлт сургалт)		Хүн нэг бүрийн бэлтгэлээр			Бүрэн салбарын жигдрэлтээр			Бүрэн болон хураангуй салбарын жигдрэлтээр		
		Цэргийн албанд дасгах	Цэргийн анхан шатны бэлтгэл	Цэргийн ерөнхий бэлтгэл	Тасаг, салааны жигдрэлт	Рот, батальоны жигдрэлт	Бататгах (хөгжүүлэх)	Бэлэн байдлыг хангах		
		7 хүртэл хоног, өдөрт 6-8 цагаар	5 долоо хоног, 7 хоногт 6 өдөр, өдөрт 8-10 цагаар	7 долоо хоног, 7 хоногт 6 өдөр, өдөрт 6-8 цагаар	7 долоо хоног, 7 хоногт 5-7 өдөр, өдөрт 6-10 цагаар	5 долоо хоног, 7 хоногт 5-7 өдөр, өдөрт 6-10 цагаар	7 хоногт 2-4 өдөр, өдөрт 6 хүртэл цагаар			
		Сургалтын хөтөлбөрийг ЗХЖШ-аас тогтооно.		ТЦК-аас тогтооно.	Хээрийн гаралтын үед өдөрт 10 хүртэл цагаар		Нэгдсэн болон хамтарсан сургууль, цэрэгжлийн спортын уралдаан, тэмцээнд оролцох боломжтой.	Тариа, ногоо хураах, хадлангийн ажилд оролцох боломжтой.		
		-	Цэргийн тангараг өргөнө.	Цэргийн мэргэжил эзэмшинэ.	Бүрэн салбар, нэгжээр үүрэг гүйцэтгэж, жигдрэлтийг хангана.		Бүрэн болон хураангуй салбар, нэгжээр үүрэг гүйцэтгэж, жигдрэлтийг хангана.			
		Бүх нэгтгэл, ангийн		ЗХЖШ-ын харьяа ангудын хөтөлбөрөөр,						
				Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын хөтөлбөрөөр,						
				Барилга-инженерийн цэргийн ангиудын хөтөлбөрөөр						

Нэмэлт сургалт	-	-	Барилга-инженерийн цэргийн ангиуд дотооддоо барилгын өргөн мэргэжлээр, Бусад нэгтгэл, ангиуд орон нутаг дахь боловсролын байгууллага (ихэвчлэн МСҮТ)-тай харилцан ажиллаж зохион байгуулж болно.	
Нийт хичээлийн	Мэргэжлийн суурь	“Цэрэг-эх оронч хүмүүжил”, “Галын бэлтгэл”, “Биеийн тамирын бэлтгэл”, “Цэргийн дүрмүүд”, “Жагсаалын бэлтгэл”, “Сэтгэл зүйн бэлтгэл”, бусад (ТЦК, УГ-ын шийдвэрээр)		30 хүртэл хувь
	Мэргэшүүлэх	“Тактик, тусгай тактик”, “Мэргэжлийн бэлтгэл” (жил бүр 70 орчим мэргэжлээр 3000 орчим ХЦАХ)		70 хүртэл хувь

Тайлбар: Давуу талыг нь өгүүлбэр актад тусгасан.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ (санал)

Хүснэгт №6

Алба хаах хэлбэр	Хэн хаах	Хугацаа (кредит цаг)	Цэргийн мэргэжил олгох			Мэргэшүүлэх			
			3 сар			3 сар		3 сар	3 сар
Биеэр хаах	Бүх хүн (18-25)	12 сар	Цэргийн албанд дасгах	Цэргийн анхан шатны бэлтгэл	Цэргийн ерөнхий бэлтгэл	Тасаг, салааны жигдрэлт	Рот, батальоны жигдрэлт	Бататгах (хөгжүүлэх)	Бэлэн байдлыг хангах
			Биеэр хаах албанд “Бага мэргэжилтэн”, “Тоот”-уудыг түлхүү бэлтгэх ба гэрээт болон дүйцүүлэх албанд “буудагч” болон бусад цэргийн мэргэжлээр бэлтгэнэ.						
			Цэргийн анхан шатны бэлтгэлийг Зэвсэгт хүчний болон төрлийн цэргийн сургалтын төвүүдэд бэлтгэж, тангараг өргүүлсний дараа сонгон шалгаруулах замаар “цэргийн ерөнхий бэлтгэл”-д хамруулж, цэргийн мэргэжил эзэмшүүлж болно.						
“Оюутан цэрэг” (560 цаг)	Бүх сургуулийн I, II дамжааны оюутан (18-25)	24 сар	I	I дамжаандаа 3 сарын хугацаатай тэнцэх кредит цагийг онол болон дадлагаа (жагсаал, биеийн тамир, зэвсэг, техникийн бэлтгэл) цуглуулна.		Их, дээд сургуулийн мэргэжлийн тэнхим болон ҮБХИС, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас онолын сургалтыг зохион байгуулна. Сургалтын хэрэглэгдэхүүнийг Зэвсэгт хүчнээс төлбөртэйгээр бэлтгэж өгнө.			
			II	II дамжаандаа 3 сарын хугацаатай “цэргийн анхан шат”, “ерөнхий бэлтгэл”-ийн хөтөлбөрийг хангаж, “тасаг, салааны жигдрэлт”-д оролцож, “цэргийн тангараг” өргөнө.			Эмч, багш нар гээд бүгд биеэр алба хаана.		
“Цэргийн сургуулийн	ҮБХИС-ийн оюутан	24 сар	I	“Оюутан цэрэг”-тэй төсөөтэй сургалт явагдах болов ч “офицер-бэлтгэл үүрэгтэн”-ээр бэлтгэгдэнэ.			Сургалтын хэрэглэгдэхүүнийг Зэвсэгт хүчнээс хангаж өгнө.		
			II						

сонсогч”					
“Гэрээт цэрэг”	Ихэвчлэн Барилга-Инженерийн ангиудад бэлтгэнэ. (18-25)	6 сар		Хугацаат цэргийн албаны хагас жилийн хөтөлбөрийг бүрэн хангана.	Алба хаах хугацаандаа 3-6 сарын хугацаатай иргэний мэргэжил эзэмшинэ.
		Өөрийн хүсэлтээр 12-24 сарын хугацаатай гэрээ байгуулж, “гэрээт цэргийн цол”, “цалин”, “томилолтын мөнгө” авна. Гэрээг 1-2 удаа сунгаж болно.			
Дүйцүүлэх алба-1	Биеэр алба хаах боломжгүй иргэд (18-)	24 сар	I II	Шинэ дайчдыг цэрэг татлагын үед биеэр “анхан” болон “ерөнхий бэлтгэл”-ийг 2 удаагийн ирэлтээр хааж, хөтөлбөрийг хангана. Ерөнхий бэлтгэлийг хангасны дараа “цэргийн тангараг” өргүүлнэ.	Хоол, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг иргэн даана.
Дүйцүүлэх алба-2	1 удаагийн хуулиар	3 сар		Цэргийн анхан болон ерөнхий бэлтгэлд хамрагдаж, тасаг, салааны жигдрэлтийн дараа “цэргийн тангараг” өргөж, гол төлөв “буудагч” мэргэжил эзэмшинэ.	Зэвсэгт хүчний болон төрлийн цэргийн Сургалтын төвүүдэд 1000, 1000-аар нь сургаж бэлтгэнэ. Сурах бичиг гарын авлага бэлэн тараагдсан байна.
		Иргэний хамгаалалтын чиглэлээр сургах боломж илүүтэй байна.			Хоол, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг иргэн даана.

Тайлбар: Дүйцүүлэх албаны цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн хөтөлбөр, стандарт нь хугацаат цэргийн жилийн сургалт бэлтгэлийн эхний хагас жилийнхтэй дүйцсэн хугацаа, кредит цагаар хэмжигдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНЫ ТАЛААРХ НИЙГМИЙН ХАНДЛАГАД ХИЙСЭН СУДАЛАГААНЫ ДҮН

Хугацаат цэргийн албаны талаарх нийгмийн сэтгэл зүйн чиг хандлага, хугацаат цэргийн алба хаах тухай иргэдийн байр суурийн талаарх судалгаа, байр суурийг тодорхойлж, судалгааны үр дүнд суурилсан санал, зөвлөмж боловсруулах зорилготой социологийн судалгааг төслийн ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 19-ний өдрийн хооронд Google forms платформыг ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулж явуулав.

Энэхүү цахим социологийн судалгааг төслийн судалгааны багаас тусгайлан бэлтгэж, БХЭШХ-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталсан социологийн судалгааны арга зүй, удирдамж, асуулгын анкетаар явууллаа.

Тус судалгааг явуулахдаа санамсаргүй түүвэр судалгааны арга зүйг ашиглан түүврийн хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжээр зохион байгуулав. Санамсаргүй түүврийн аргаар судалгааг явуулахдаа 2,1 сая эх олонлогоос төлөөлөх чадварыг сайжруулах үүднээс судалгааны үнэн байх магадлал 99%, түүврийн стандарт алдаа 1,5% байхаар тооцоход нийт 2091 түүвэр гарав.

Тооцоолсон түүврийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн хүрээнд 21 аймаг, Нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргийн иргэдээс тусгайлан бэлтгэсэн 23 багц асуулгаар судалгаа явуулж, түүнд нийт 7654 иргэн хамрагдсан байна.




График №1. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн салбар

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 69,8% нь төрийн албан хаагч, 14,1% нь ажилгүй, 8,5% нь хувийн хэвшилд ажилдаг, 7,7% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг байв.

Судалгаанд хамрагдсан иргэд нь насны хувьд 16-21 насны 14,3%, 22-27 насны 14,2%, 28-33 насны 15,1%, 34-39 насны 18,5%, 40-45 насны 14,1%, 46-51 насны 11,2%, 52-57

насны 9,3%, 58-аас дээш насны 3,2%, боловсролын хувьд бага 1,1%, бүрэн бүс дунд 7,6%, бүрэн дунд 29,3%, дээд 62% байгаа нь түүврийн төлөөллийн хувьд эх олонлогоо төлөөлөх бүрэн чадавхтай харагдаж байна.




График №2. Судалгаанд оролцогчдын нас, боловсролын байдал

Тухайн судалгааны зорилгыг хангахын тулд дараах асуудлуудыг багцлан асууж тодруулав. Үүнд:

1. Иргэн бүр хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн алба хаах бодит хэрэгцээ, шаардлага байгаа эсэх;
2. “Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” нь Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай болон Иргэний цэргийн үүргийн тухай хуулиар тогтоосон иргэн хүний үүрэг гэдгийг та мэдэх эсэх;
3. Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд цэргийн албанд явах эсэх;
4. Зарлан дуудах хуудас ирсэн ч явахгүй байх шалтгаан;
5. Иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахад ямар хүчин зүйл нөлөөлдөг болох талаар;
6. Иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахаас зайлсхийхэд хүргэдэг ямар хүчин зүйлүүд байдаг талаарх;
7. Иргэдийн хугацаат цэргийн алба хаах хүсэл, сонирхлыг идэвхжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах тухай санал;
8. Цэргийн алба хаах хугацааны хувьд хамгийн тохиромжтой хувилбар;
9. Хугацаат цэргийн албыг хаах нөхцөлийн талаарх санал;
10. Хугацаат цэргийн алба хаах тогтолцоог хэрхэн шинэчлэх тухай санал зэрэг болно.

Цэргийн насны залуучуудын цэргийн албанаас зайлсхийх шалтгаан, нөхцөлд нийгмийн харилцаан дахь бусад олон хүчин зүйл нөлөөлж байдаг ч иргэн үндсэн хуулиар

хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж цэргийн алба хаахад хугацаат цэргийн алба хаах хугацаа нь шууд нөлөө үзүүлэгч хүчин зүйл болж байдаг.

Судалгаанд оролцогчид нь анкетын асуулгын хүрээнд хугацаат цэргийн албаны хугацаа, түүний шалтгаан нөхцөлийн талаар өөрсдийн байр суурь, үзэл бодлоо дараах байдлаар илэрхийлсэн байна.

Иргэн бүр хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн алба хаах бодит хэрэгцээ, шаардлага байгаа эсэх талаар асууж тодруулахад 77,2% нь байгаа, 5,9% нь байхгүй, 11,5% нь энэ нь тийм ч чухал биш гэж хариулсан бол 5,4% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Хариултаас үзвэл судалгаанд оролцогч иргэдийн дийлэнх нь эр хүн бүр хугацаат цэргийн алба хаахыг дэмжиж байгаа нь харагдаж байна. Тэдний судалгаанд илэрхийлсэн байр суурийн цэргийн алба хаах хэрэгцээ “байгаа” болон “байхгүй” гэсэн хариултыг сонгосон шалтгааныг товчлон харуулав.

Цэргийн алба хаах хэрэгцээ байгаа гэж үзсэн шалтгаан:

1. Эр хүн бүр эх орноо хамгаалахад тодорхой хэмжээний мэдлэг ур чадвартай байхын тулд цэргийн алба хийх;
2. Эр хүн бүр эх орноо хамгаалах үүргээ ямар нэгэн аргаар биелүүлэх үүрэгтэй. Жишээ нь эрүүл мэндийн эсвэл өөр шалтгаанаар биеэрээ хаах боломжгүй бол дүйцүүлэх, мөнгөн хэлбэр гэх мэт аргаар эр хүний үүргээ биелүүлэх;
3. Цэргийн алба хаах нь сахилга бат, тэсвэр хатуужил, бие бялдар болон сэтгэл зүйг зөв сургаж төлөвшүүлэх олон талын ач холбогдолтой. Мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, халдашгүй дархан байдлыг хамгаалах цэрэг эрсийг бэлтгэдэг учир;
4. Эх оронч хүмүүжилтэй хүн болж төлөвшинө;
5. Эр хүн эх орныхоо халдашгүй дархан байдлыг хангах бэхжүүлэхэд бага ч болтугай хувь нэмрээ оруулах үүднээс цэргийн албыг биеэр хаах ёстой;
6. Ачаалал даах чадвартай, аливаа зүйлд буурь суурьтай, олон нийттэй харьцах тал дээр ч гэсэн тодорхой хэмжээний сайн нөлөөтэй;
7. Эх орны өмнө хүлээх том үүрэг гэж ойлгодог. Мөн төрийн албанд орох цэргийн албыг биеэр хаасан бол давуу эрх болно;
8. Цэргийн алба хаасан 1 жил тэр хүнд насан туршийн боловсрол, амьдралд нь хэмжээшгүй их нөлөө үзүүлдэг хэлэхийн аргагүй боловсрол олгодог;
9. Эр хүн бүр заавал цэргийн албыг биеэр хаах ёстой. Энэ бол үндэсний аюулгүй байдал эх орны аюулгүй байдлын баталгаа, Эх оронч хүмүүжлийг олгох үндсэн арга;
10. Залуучуудыг багаас нь эх оронч үзэл сурталтай болгох, зөв хүн болж төлөвших, нийгмийн оролцоо сайжирч нэмэгдэх зэрэг ач тустай;

11. Монгол улсын иргэн болж төрсөн л бол хуульд заасанчлан иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн албыг хаах нь зүйтэй;

12. Хүн ам цөөн улс бүх нийтийн дайчилгааны их хэмжээний нөөцтэй байх зайлшгүй шаардлагатай. Иймд хүн бүр цэргийн хэрэгт бэлтгэгдсэн байх нь маш чухал;

Цэргийн алба хаах хэрэгцээ байхгүй гэж үзсэн шалтгаан:

1. Хууль бус хөдөлмөр эрхлэлт, нас баралт гарч байгаа тул миний хувьд лав хүүгээ явуулах зориг хүрэхгүй байна;

2. Сурч боловсорч ажиллаж хөдөлмөрлөж байгаа хүнийг заавал цэргийн алба хаа гэж шаардмааргүй байна;

3. Одоогийн цэргийн алба дүрмийн бус харьцаа, дэг яргалал ихтэй энхийн цагт залуус амь эрсдэж байна;

4. Хүүхдүүд цэрэгт эрүүл саруул яваад эргэж ирэхгүй тохиолдлууд гарч байна. Ийм нөхцөлд хүүхдээ амьд ирэхийг мэдэхгүй байж цэрэгт явуулна гэдэг том эрсдэл хүлээж байгаа хэлбэр гэж үзэж байна.

5. Цэргийн алба хаах хугацаанд нь эрүүл мэнд, амь насыг баталгаатай хангаж байж л иргэнийг цэрэгт татдаг болох хэрэгтэй.

6. Цэрэгт оны ялгаа, цол зэргийн ялгаа, дээрэлхэлт их байдаг, хүний эрхийг хамгийн их зөрчдөг тул энэ тогтолцоог засах хэрэгтэй.

Судалгаанд оролцсон иргэдээс “Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” нь Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай болон Иргэний цэргийн үүргийн тухай хуулиар тогтоосон иргэн хүний үүрэг гэдгийг та мэдэх үү гэх асуултыг асуухад 95,4% нь мэднэ, 4,6% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнээс харахад иргэд иргэний үүргээ биелүүлж цэргийн албыг хаах ёстойг бараг бүгд буюу дийлэнх хувь нь мэддэг болох нь харагдаж байна.

Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд цэргийн албан явах уу гэсэн асуултад судалгаанд оролцогчдоос асуухад 73,2% нь тийм гэж хариулсан бол 26,8% нь үгүй гэж хариулсан байна. Үүнийг судалгаанд оролцогчдоос тодруулж нарийвчлан “Яагаад тийм” гэж хариултыг сонгосон тухай асуухад:

- Эх орноо хамгаалахад өөрийн хувь нэмрээ оруулах 59,8%
- Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нь иргэний үүрэг гэж үзсэн 40,2%

Харин “Яагаад үгүй” гэж сонгосон тухай асуухад:

- Гэр бүлээ дэмжихийн тулд ажлаа хийх шаардлагатай 33,2%

- Сурч байгаа сургуулиасаа завсардах сонирхолгүй байна 28,3%
- Цэргийн албыг биеэр бус, мөнгөн төлбөрөөр дүйцүүлж хаах сонирхолтой 21%
- Хүссэн ажилдаа орсон тул ажлаа алдахыг хүсэхгүй байна 17,5%




График №3. Зарлан дуудах хуудас ирсэн тохиолдолд цэргийн албанд явах эсэх тухай

Зарлан дуудах хуудас ирсэн үед цэргийн албанд явахгүй гэж байгаа бас нэг хүчин зүйл нь олон нийтийг бухимдуулсан цэргийн алба дахь гэмт хэрэг зөрчил, дүрмийн бус харьцааны асуудал, алба хаах орчин нөхцөл, цэргийн албаны хуучинсаг харилцаа хандлага, иргэд сонгох боломжтой алба хаалгах олон төрөл хэлбэр дутмаг байдал зэрэг судалгаанд дурдагдсан бусад олон хүчин зүйлс нь иргэдийн алба хаах сонирхолд сөргөөр нөлөөлсөн байх магадлалтай байна.

Иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахад ямар хүчин зүйл нөлөөлдөг болох талаар судалгаанд оролцогчдоос асуухад төрийн албанд орохын тулд цэргийн алба хаасан байх шаардлагатай 38%, өөрийн хүч, боломж, тэсвэр хатуужлаа сорьж үзэх зорилгоор 28%, өөрийгөө хөгжүүлэх боломж гэж үзсэн 23,5%, ар гэр бүл, найз нөхдийн дарамт шахалт, ятгалгаар цэргийн алба хаадаг 5,1%, цэргийн сургуульд элсэн орж чадаагүй нөхцөлд байж болох сонголт 2,3%, цэргийн зэвсэг, техник, дүрэмт хувцас сонирхолтой санагдсан 3,1% зэргээр хариулсан байв.

Харин цэргийн албанаас зайлсхийхэд хүргэдэг хүчин зүйлсийн талаар тодруулахад иргэдийн голчлон өгч буй хариултуудад цэргийн албатай холбоотой дэглэлт, дүрмийн бус

харьцаа зэрэг сөрөг мэдээлэл их байдаг 49,7%, аюул эрсдэлтэй гэж боддог 13,5%, цэргийн албанд амьдралынхаа нэг жилийг зарцуулахаар чухал ач холбогдолтой зүйл гэж үздэггүй 12,3%, ажил, сургууль, гэр бүлээсээ нэг жил хөндийрөх нь хүндрэлтэй санагддаг 12,3%, шашин шүтлэг, ёс зүйн бусад шалтгаан 1,4% тус тус байв. Судалгаанд оролцогчдоос цэргийн албанаас зайлсхийхэд хүргэдэг асуудлыг нарийвчлан тодруулахад дараах гол хүчин зүйлүүдийг дурдсан байна. Үүнд:

- Цэргийн алба хаах орчин нөхцөл сайн биш,
- Хүний эрх, эрх чөлөө хязгаарлагддаг,
- Амьдралын цаг хугацаа үрсэн алба болсон,
- Цэргийн сургалт бэлтгэл бус аж ахуйн ажил их хийлгэдэг,
- Алба хаах төрөл, хэлбэр сонголт бага.

Цэргийн алба хаах хүсэл, сонирхлыг идэвхжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах нь зохистой талаар асуултыг судалгаанд оролцогчдоос асуухад “Оюутан цэрэг” маягийн богино хугацааны эрчимтэй сургалтын хамрах хүрээг өргөжүүлэх 25,9%, хугацаат цэргийн алба хаасан залууст үзүүлэх хөнгөлөлт урамшуулал /сургалтын төлбөр, орон сууцны зээл, эрүүл мэндийн үйлчилгээний хөнгөлөлт/ өгөх тогтолцоог бий болгох 24,2%, цэргийн албыг залуус бие бялдар, сэтгэл зүй, амьдрах ухаан, тэсвэр хатуужил, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх хөгжлийн орчин болгон шинэчлэх 19,1%, залуучууд ажил, амьдралаа зохицуулан хүссэн цагтаа цэргийн анги, байгууллагатай гэрээ байгуулан богино хугацааны сургалтад хамрагдах замаар алба хаах нөхцөлийг бүрдүүлэх 17,2%, цэргийн албатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох 13,7% тус тус үзсэн байна.




График №4. Цэргийн алба хаахад хугацааны хамгийн тохиромжтой хувилбар

Судалгаанд оролцогчдоос цэргийн алба хаах дараах хугацаануудаас хамгийн тохиромжтой хувилбар юу вэ гэсэн асуулт асуухад иргэдийн бараг тал хувь буюу 47,5% одоогийн 12 сараар хаах хугацааг хамгийн тохиромжтой гэж үзэж байгаа бол 6 сараар хаах 27,8%, 24 сараар хаах 12,2%, 18 сараар хаах 3,6%, 8 сараар хаах 3,9% тус тус байна. Үүнээс үзэхэд иргэдийн олонх нь одоо байгаа хугацаа 1 жил хаахыг тохиромжтой хэмээн үзэж байна. Хамгийн тохиромжтой хугацааны талаар нарийвчлан тодруулахад дараах нэмэлт саналууд ирсэн ба үүнд:

- 6 сар зөвхөн цэргийн хэрэгт суралцаад халагдах
- 18 сар цэргийн алба хаах, ингэхдээ 9 сар цэргийн хэрэгт суралцаад, 9 сар бүтээн байгуулалтад оролцох
- 24 сар цэргийн алба хаах, ингэхдээ 12 сар цэргийн хэрэгт суралцах, 12 сар бүтээн байгуулалтад оролцох
- Оюутан цэрэг сургалтаар хугацаат цэргийн алба хаах
- Иргэн өөрийн сонгосон хугацаандаа уян хатан, хэсэгчлэн сонгож алба хаах боломж олгосон хувилбар

Мөн иргэдээс цэргийн алба хаах тогтолцоог хэрхэн шинэчлэх хэрэгтэй талаар асуулт асуухад дараах байдлаар хариулсан байна.

- Алба хаах хугацааг богино болгож сургалтыг эрчимжүүлэх 33,8%
- Алба хаах хугацааг нэмж чанаржуулах 13%
- Алба хаах хугацаа хэлбэрийг уян хатан олон хувилбартай болгох 24,9%
- Хугацаат цэргийн албаны сургалт, бэлтгэлийг сайжруулах 20,1%
- Хугацаат цэргийн албаны орчин нөхцөлийг сайжруулах 25,7%
- Цэргийн алба дахь дарамт шахалт, дэглэлтийг арилгах 35,9%
- Цэргийн алба дахь гэмт хэрэг, хөдөлмөрийн осол зөрчлийг багасгах 20,1%
- ЕБС-ийн сурагч байхаас нь эх оронч үзэл төлөвшүүлж цэргийн алба хаах хүсэл сонирхлыг төрүүлэх сургалт зохион байгуулах 7,8%
- Цэргийн алба хааж буй хүний банк болон банк бус байгууллагаас авсан зээлийн хөнгөлөлтөд уян хатан байдлыг бий болгох 6,9%
- Шүүх прокурор дээр байгаа хэргийг цэргийн алба хаах хугацаанд хойшлуулж өгөх

Цаашид хугацаат цэргийн албанд иргэдийг тэгш байдлаар аль болон өргөнөөр хамруулж, эх орноо батлан хамгаалах зохих бэлтгэл эзэмшсэн иргэд (дайчилгааны нөөц)-ийн тоог нэмэгдүүлэхийн тулд **дараах саналыг дэвшүүлж** байна. Үүнд:

- **Хууль эрх зүйн шинэчлэлтээр** алба хаах хэлбэрүүдийг өөрчлөх, нэмэгдүүлэх (олон хувилбартай);

- **Хэлбэр тус бүрт тохирсон алба хаах нөхцөл**, хугацаа, сургалтын онцлогийг журамлах (ХЦАХ-дын идэвхтэй сургалтын 6 сарын хугацааг кредит цагт шилжүүлэх, бие дааж болон биеэр хаах хэлбэрийг хослуулан алба хаах хэлбэрүүдийг нэмэгдүүлж, ижил стандартад шилжүүлэх);

- Иргэд хувцас хэрэгслээ өөрөө бэлтгэж, сайн дураар цэргийн албаны шаталсан сургалтад жил тутам богино хугацаагаар хамрагдах замаар 3-4 жилийн хугацаанд биеэр алба хаадаг уян хатан тогтолцоог бий болгох;

- Хугацаат цэргийн алба хаах **төсөв, зардлыг нэмэгдүүлэх.**

- Нэгтгэл, ангиудын **цэргийн байр**, сургалтын материаллаг баазыг **сайжруулах.**

- Цаашид цэргийн ангиудыг түшиглэсэн **сургалтын төвүүдийг нэмэгдүүлэх**, төхөөрөмжлөх;

- Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын **цолыг ялгавартай болгох**, ХЦАХ-дад 3-4 төрлийн цолыг олгодог болгох;

- ХЦАХ-дыг **цэрэг хувцастай**, аранз (котель, манерк, бусад хэрэглэж байсан зүйлтэй нь)-тай нь **халдаг байх**;

- **Хугацаат цэргийн албыг 2 ээлж болгох мөн сайн дурын үндсэн дээр богино хугацааны шаталсан сургалтад хамрагдах иргэдийг элсүүлснээр** анги, салбарын сургалт үр дүнтэй явагдах, байнгын бүрэлдэхүүний сургалт тасалдахгүй байх зэрэг давуу талтай;

- Түүнчлэн ЕБС, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “цэрэг-эх оронч үзэл, төлөвшил” (түүхийн хичээлээр), цэргийн албаны тухай болон цэргийн ерөнхий эрдмийн сургалт (биеийн тамирын бэлтгэл, жагсаалын бэлтгэл, амьд гарах арга ухааны бэлтгэл гэх мэт)-ыг оруулдаг байх. Ингэснээр хугацаат цэргийн албанд биеэр алба хаах хугацааг богиносгох, сургалтын агуулга, хөтөлбөр нь шинэчлэгдэж, чанаржих төдийгүй алба хаах хүсэлтэй, чадвартай хүмүүсийн тоо нэмэгдэнэ.

- ХЦАХ-дын “анхан шатны бэлтгэл”-ийг бүсчилсэн сургалтын төвүүдэд нэгдсэн журмаар зохион байгуулах, тэндээс зан төлөв, хүсэл сонирхол, чадавхид нь тулгуурлан “ерөнхий бэлтгэл”-ээр мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн анги, салбаруудад хуваарилдаг байх.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нэг. Хугацаат цэргийн албаны алба хаах хугацааны талаар:

I. Хугацаат цэргийн алба хаах өнөөгийн 1 жилийн хугацааны талаар.

1. Судалгаанаас хийсэн дүгнэлт:

Хугацаат цэргийн алба хаах өнөөгийн 1 жилийн хугацаа нь илүү тохиромжтой хугацаа гэсэн дүгнэлтэд олон нийтийн санаа бодол хүргэж байна.

2. Үндэслэл:

1) Хугацаат цэргийн албыг 1 жил байлгах нь тохиромжтой гэдэг дээр олон нийтийн санал бодол давамгайлж байна. Тухайлбал:

а) 2010 оны судалгаагаар 6 сар, 12 сар, 18 сар, 24 сар алба хаахаас аль хугацаа нь тохиромжтой болох талаарх санал асуулгад судалгаанд оролцогчдын 56% нь өнөөгийн 1 жилээр алба хаах хугацааг тохиромжтой гэж хариулсан.

б) 2021 оны судалгаагаар 62.2% нь өнөөгийн 1 жилээр алба хаах хугацааг тохиромжтой гэж хариулсан нь 2010 оны судалгааны үр дүнгээс 6.2 пунктаар өссөн байна.

с) 2023 оны судалгаагаар 64.2% нь өнөөгийн 1 жилээр алба хаах хугацааг хамгийн тохиромжтой хугацаа гэж үзсэн байна. Ийм үзүүлэлт нь олон нийтийн санаа бодол 1 жилийн алба хаах хугацааг дэмжих байдал 2010 оныхоос 8.2, 2021 оны судалгааны үр дүнгээс 2.0 пунктаар тус тус өссөн дүнтэй байна. .

2) “Хугацаат цэргийн албыг дараах нөхцөл байдлаар хаахыг санал болговол Танд аль хувилбар нь илүү тохиромжтой санагдаж байна вэ” гэсэн асуулгад 7 хувилбар санал болгоход судалгаанд оролцогчдын 49.2% нь “1 жилийн хугацаанд цэргийн хэрэгт суралцаад халагдах одоогийн тогтолцоо” хувилбарыг хамгийн тохиромжтой гэсэн санал өгсөн. Энэ нь дараагийн өндөр санал авсан хувилбараас даруй 22.3 пунктаар илүү байна.

3) Хугацаат цэргийн албаны талаарх олон нийтийн санал бодлыг www.ikon.mn сайтаар 2021 оны 10 дугаар сарын 25-нд тандсан судалгаагаар 7969 оролцогчдын 88.3 хувь нь хугацаат цэргийн алба хаах хугацааг сунгахыг эсэргүүцсэн байхад www.twitter.com орчинд 1223 хүн хамрагдсан судалгаанд 4 хугацаагаар тандалт хийхэд 24 сар болгох нь тохиромжтой гэж тэдний 31.6 хувь нь үзсэн нь олон нийтийн санаа бодол боловсролын түшингээс ихээхэн хамаарч болохыг илтгэж байна. Өнөөгийн байгаа 1 жилийн хугацааны албыг 31.4 хувь нь дэмжсэн байна.

Эдгээр үр дүнгээс дүгнэлт хийхэд олон нийтийн санаа бодол хугацаат цэргийн алба хаах хугацааг өнөөгийн 1 жил хэвээр байлгах нь тохиромжтой гэж үзэж байна

3. Хугацааг 1 жил байлгахад цаашид анхаарах асуудлын талаарх зөвлөмж:

Цаашид цэргийн мэргэжил эзэмшүүлэх үндсэн зорилгод илүүтэй анхаарч доор өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх нь ач холбогдолтой байх болно.

- 1) Хугацаат цэргийн алба хаагчид зөвхөн чанартай цэргийн мэргэжил эзэмшүүлэхэд чиглүүлэн сургалтыг зохион байгуулах. Үүний тулд бусад арга хэмжээнд зориулагдаж байгаа сургалтын цагийн 40-50%-ийн тасалдлыг арилгах.
- 2) Хугацаат цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагын хотхон, дуурайлган үзүүлэх симуляцын тоног төхөөрөмжийн хангалтыг байвал зохих түвшинд хүргэх арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх. Үр дүнд нь практик дадлага хийх боломж нэмэгдэнэ.
- 3) Сургалт зохион байгуулах даргалах бүрэлдэхүүнийг чадваржуулах арга хэмжээ авах. Үр дүн нь өнөөдөр даргалах бүрэлдэхүүний ажлын арга барил, заах арга зүйд оршиж буй дутагдлыг арилгах ба олон нийтийн санал бодлын сүүлийн хэд хэдэн судалгаанд байнга дурдагдаж байгаа даргалах бүрэлдэхүүнтэй холбоо бүхий дутагдалтай талд иргэдийн эерэг уур амьсгал бий болгох ач холбогдолтой.
- 4) Орон нутгийн хамгаалалтын арга хэмжээний хүрээнд иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулах.

Олон нийтийн санаа бодлын 2023 оны судалгааны “Хугацаат цэргийн алба хаах тогтолцоог яаж шинэчлэх хэрэгтэй вэ?” гэсэн асуулгад: судалгаанд оролцсон 7654 иргэд, цэргийн албан хаагчид давхардсан тоогоор 35.9 хувь нь “Хугацаат цэргийн албаны орчин нөхцөлийг сайжруулах”, 35.6 хувь нь “Цэргийн албан дахь дарамт шахалт, дэглэлтийг арилгах”, 33.5 хувь нь “Хугацаат цэргийн албаны сургалт, бэлтгэлийг сайжруулах” шаардлагатай байна гэж тус тус санал өгсөн нь эхний гуравт эрэмбэлэгдэж байгаа бөгөөд эдгээр шаардлагыг хангахад дээрх арга хэмжээнүүд чнал үүрэг гүйцэтгэх болно.

II. Хугацаат цэргийн алба хаах хугацааг 6 сар болгох боломжийн талаар

1. Судалгаанаас хийсэн дүгнэлт:

Хугацаат цэргийн алба хаах хугацааг 6 сар болгох боломж байна. Үр дүнд нь: улс орны эдийн засгийн чадамж сул байхад нэг хугацаат цэргийн алба хаагчид цэргийн мэргэжил олгоход гаргах зардал багасна, мөн Дайчилгааны нөөц бэлтгэх боломж нэмэгдэнэ. Зөвхөн хугацааг 6 сар болгосноор гарсан зардлын хэмнэлтээр тодорхой тооны хугацаат цэргийн алба хаагчийг нэмж авч дайчилгааны нөөцийг бэлтгэх боломжтой. Гагцхүү ийм хугацаанд шилжихийн тулд зохих бэлтгэл ажил шаардлагатай байх болно.

2. Үндэслэл:

- 1) Цэргийн албаны хугацааг 6 сар болгож багасгах боломжтой талаар Цэргийн тагнуулын газрын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн мн/550 тоот албан бичгээр ирүүлсэн тооцоотой судлаачид бид санал нэг байна. Тооцооны үндэслэлд:
 - а) Алба хаах хугацааны хувьд: цэргийн бүртгэлтэй мэргэжил эзэмших сургалтын мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээл, бэлэн байдал хангах дадлагын өнөөгийн мөрдөж буй цагийн тооцоон дээр тулгуурлан гаргасан байна.
 - б) Нэг албан хаагчид цэргийн мэргэжил эзэмшихэд гарах зардлын хувьд: өнөөгийн гаргаж буй зардлын ангиллаар нэг хүнд жилд зарцуулах шатахуун болон сум галт хэрэглэлийн зардлыг хэвээр хадгалж бусад зардлыг хоёр дахин багасна гэж тооцсон байна.
- 2) ЗХЖШ-ын сургалтын хэлтсээс авсан тооцоогоор ХЦАХ-д жилд 500 гаруй цагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөдөг боловч 50-60 хувь нь л хэрэгждэг байна. Бусад хугацаа нь цэрэгжлийн спортын уралдаан, тэмцээн, бүтээн байгуулалтын болон улс ардын аж ахуйн ажилд оролцоход зарцуулагдаж байна.Тиймээс энэхүү эмпирик өгөгдөлд тулгуурлавал энэ нь хугацаат цэргийн албаны хугацааг 6 сар болгох үндэслэл байх болно.
- 3) Оюутан цэргийг 4 сарын сургалтаар цэргийн мэргэжил эзэмшүүлж байгаа туршлага хугацаат цэргийн албыг 6 сар хаалгаж цэргийн мэргэжил олгох боломжтой гэж үзэх нэг үндэслэл болж байна.
- 4) Харин Хугацаат цэргийн алба хаах хугацааны тохиромжтой хувилбарын талаарх олон нийтийн санал бодлын судалгааны хоёр хувилбарын дүнгээс үзэхэд:
 - а) 1 жилийн алба хаах хугацааг: 2010 оны судалгаанд оролцогчдын 9% , 2021 оны судалгаанд оролцогчдын 11.3% нь тус тус их байна гэсэн бол 2023 оны судалгаанд оролцогчдын 6.8% нь их байна гэж санаа бодлоо илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл, алба хаах хугацааг багасгах нь зүйтэй гэсэн иргэдийн тоо тогтвортой бус хэлбэлзэлтэй байгаа дүр зураг харагдаж байна.
 - б) 6 сарын алба хаах хугацааг: 2021 оны судалгаанд оролцогчдын 26.1% , 2023 оны судалгаанд оролцогчдын 11.9% тус тус илүү тохиромжтой гэж үзсэн байна. богино хугацаанд алба хаах боломж байгааг дэмжигчид нэмэгдэж байгааг харуулж байна.

3. Хугацааг 6 сар болгох тохиолдолд анхаарах асуудлын талаарх зөвлөмж:

- 1) Нэг жилийн алба хаахад гаргаж байсан сургалтын 40-50 хувийн хийдлийг арилгасан байх. Цэргийг бусад ажилд дайчлахгүйгээр зөвхөн цэргийн мэргэжил эзэмшүүлэхэд анхаарснаар энэ асуудал шийдэгдэнэ.

- 2) Хугацаат цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагын хотхон, дуурайлган үзүүлэх симуляцын тоног төхөөрөмжийн хангалтыг байвал зохих түвшинд хүргэсэн байх шаардлагатай. Чингэснээр Хугацаат цэргийн алба хаагчидтай дадлагын хичээлийг илүүтэй зохион байгуулах боломж бүрдэнэ.
- 3) Хугацаат цэргийн алба хаагчдын сургалтын агуулга, төлөвлөлтийг нягтруулах, зохион байгуулалтын арга барилыг сайжруулах, даргалах бүрэлдэхүүний заах арга зүй, харилцааны соёлыг дээшлүүлсэн байх.
- 4) Нэг цэргийн албан хаагчид ноогдох шатахууны болон сум галт хэрэглэлийн зардлыг эзэмшвэл зохих цэргийн мэргэжлийн ангилалтай уялдуулан ялгавартайгаар тогтоосон байх.

III. Хугацаат цэргийн алба хаах хугацааг уртасгах боломжийн талаар:

1. Судалгаанаас хийсэн дүгнэлт:

Хугацаат цэргийн алба хаах хугацааг уртасгах асуудлыг одоо авч хэлэлцэхгүй байх нь зүйтэй байна. Цэргийн алба хаах хугацааг уртасгах асуудлыг хэлэлцэх нь цэрэг дайны аюул илэрхий болсон гэсэн санааг илэрхийлэх ба энэ нь хөрш орнуудад буруу ойлголт төрүүлэн улмаар улс төр, эдийн засгийн эрсдэл бий болгох боломжтой.

2. Үндэслэл:

- 1) Гадаад улс орнуудын хугацаат цэргийн алба хаах хугацааны талаар хийсэн судалгаанаас үзэхэд тухайн улсын цэрэг улс төрийн нөхцөл байдал харьцангуй тайван байхад алба хаах хугацааг уртасгаж нэмсэн улс орон байхгүй байна.
- 2) Тайваний засгийн газар 2022 оны 12 дугаар сард 2013 оноос хойш 4 сарын цэргийн бэлтгэлд хамрагдаж алба хааж байсан тогтолцоог өөрчилж 1 жил болгон уртасгасан. Ийм шийдвэр нь дараах үндэслэл дээр тулгуурласан байна. Үүнд:
 - a) АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын дарга Н.Пелосогийн Тайваньд хийсэн айлчлалтай холбогдуулан ХАЧА Тайванийн хоолойд төлөвлөгдөөгүй бүрэн хэмжээний цэргийн хээрийн сургуулилыг 2022 оны 8 дугаар сарын 3-10-ны өдрүүдэд ХАЧА-ийн сүр хүчийг дэлхий дахинд харуулах, Тайваний арлыг цэргийн хүчээр эзлэх хувилбарыг шалгах зорилготойгоор явуулсан.
 - b) ХКН-ын 20 дугаар их хурлаар анх удаа “Тайванийн тусгаар тогтнолыг эрс эсэргүүцнэ” гэсэн заалтыг намын дүрэмд тусгасан.
 - c) Тайваний 2022 оны 12 дугаар сарын 20-нд гаргасан олон нийтийн санал асуулгын дүнгээр нийт оролцогчдын 73.2% нь цэргийн албыг нэг жил болгож сунгахыг зөвшөөрсөн байна.

Гадаад улс орнуудын хугацаат цэргийн алба хаалгадаг туршилага: нэгд, өөрийн улс орны хувьд цэрэг-улс төрийн нөхцөл байдал харьцангуй тайван байхад хугацаат цэргийн алба хаах хугацааг уртасгадаггүйг, хоёрт, өөрийн орны хувьд цэрэг-улс төрийн нөхцөл байдал хурцадсан үед л алба хаах хугацааг урт болгох асуудал гардгийг, гуравт, хугацаат цэргийн алба хаалгах хугацааг урт болгох шийдвэрийг олон нийтийн санаа бодол дээр тулгуурлан гаргадгийг харуулж байна.

- 3) Хугацаат цэргийн албаны талаарх олон нийтийн санал бодлыг www.ikon.mn сайтаар 2021 оны 10 дугаар сарын 25-нд явуулсан “1.6-2 жилийн хугацаанд цэргийн алба хаадаг болох тогтолцоо руу шилжих саналыг та дэмжиж байна уу?” гэсэн асуулт бүхий санал асуулгад 7969 хүн саналаа өгснөөс 88.3 хувь нь “Үгүй” хэмээн хариулж дэмжихгүй байгаагаа илэрхийлжээ. Харин www.twitter.com орчинд “Цэргийн алба хаах ямар хугацааг та тохиромжтой гэж үзэж байна вэ?” санал асуулгад 1223 хүн хамрагдсанаас 31.6 хувь нь 24 сар болгохыг дэмжсэн байна. Энэ үзүүлэлт нь 1 жил алба хаахаас 0.2 пунктаар их, 6 сар алба хаахыг дэмжигчдээс 0.7 пунктаар бага бөгөөд хоёрт эрэмбэлэгдсэн нь хугацааг уртасгахыг дэмжигчид сэхээтнүүдийн дунд бас цөөнгүй байгааг харуулж байна.

Энэ тандалтыг нэгтгэн авч үзвэл хугацаат цэргийн алба хаах хугацааг 2 жил болгож өөрчлөхийг хүн амын бүхий л давхаргыг хамарсан дийлэнх олонх нь дэмжихгүй байна.

Хоёр. Хугацаат цэргийн албанд татагдагчдыг алба хаах сонирхлыг өрнүүлэх арга зам.

I Гэрээт цэргийн албыг сайжруулах замаар хугацаат цэргийн албанд татагчдын сонирхлыг өрнүүлэх арга зам

1. Хугацаат цэргийн алба хаагчдыг алба хаасны дараа гэрээт цэргийн албанд үлдэх боломж олгох.

- 1) Барилга, инженерийн цэрэгт татагдсан хугацаат цэргийн алба хаагчдын д сургалтыг бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд гэрээт цэргийн алба хаагчдыг дагалдан оролцох боломж бүрдүүлэх. Үүний тулд:

- а) Гэрээт цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтад өргөнөөр оролцуулах нөхцөл бүрдүүлсэн байх.
- б) Гэрээт цэргийн алба хаагчдыг барилга-инженерийн цэргийн мэргэжлээр мэргэшүүлж мэргэжлийн цэрэг болгосон байх шаардлагатай

- 2) Гэрээт цэргийн алба хаагчдыг энхийг дэмжих ажиллагаанд оролцох боломж бүрдүүлэх замаар хугацаат цэргийн алба хаагчийг алба хаасны дараа гэрээт цэргийн албанд орох эрмэлзлийг өдөөх.

II. Өсвөр үеийнхнийг үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх” зарчмаар төлөвшүүлж хугацаат цэргийн алба хаахыг өөрийн эрхэм үүрэг гэж ойлгодог нөхцөл бүрдүүлэх.

- 1) Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт заасанчлан “Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд залуучуудын цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж хэрэгжүүлэх” ажлыг боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулах.
- 2) Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт заасан “Эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгох”, “Цэргийн албыг биеэр болон хуульд заасан бусад хэлбэрээр хаагаагүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс бүрдүүлэх”, “Төрийн албанд анх орж байгаа иргэнд цэргийн алба хаасан байх шаардлага тавих” арга хэмжээнүүдийг бодитой хэрэгжүүлэх хяналтыг батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллагаас тавих, соён таниулах арга хэмжээ зохион байгуулах.
- 3) Хөнгөн замаар, барьцаа болгох замаар алба хаасанд тооцогдох, тухайлбал мөнгөөр дүйцүүлэн хаах, засаг даргын шийдвэрээр алба хаасанд тооцох, хөдөө орон нутагт ажилласан эмч, багшийг цэргийн алба хаасанд тооцох зэрэг арга мухардсан мэт бодлогоос татгалзах. Үүний оронд хөдөө орон нутгаа хөгжүүлж, орон нутгийн хамгаалах залуусын амьдрах таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай.

III. Хугацаат цэргийн алба хаах тогтолцоог шинэчлэх замаар цэргийн алба хаах сонирхлыг нэмэгдүүлэх.

- 1) ХЦА-ны талаарх олон нийтийн санал бодлын 2023 оны судалгаагаар “Таны бодлоор хугацаат цэргийн алба хаах тогтолцоог яаж шинэчлэх хэрэгтэй вэ?” асуулгад судалгаанд оролцогчид цэргийн анги, байгууллагад оршин буй дараах гурван тулгамдсан асуудлыг хамгийн өндөр үзүүлэлттэйгээр шинэчлэх шаардлагатай гэж онцолсон байна. Үүнд:
 - a) Хугацаат албаны орчин нөхцөлийг сайжруулах /35.9%/.
 - b) Цэргийн албан дахь дарамт шахалт, дэглэлтийг арилгах /35.6%/
 - c) Хугацаат цэргийн албаны сургалт, бэлтгэлийг сайжруулах /33.5%/ . Тиймээс эдгээр асуудалд эргэлт гаргах хэрэгтэй юм. Түүнчлэн энэ нь судалгаанд оролцогчдын 39.3% нь “Таны бодлоор иргэд хугацаат цэргийн алба хаахад ямар шалтгаан,

хүчин зүйл саад болж байна вэ?” асуулгад “цэргийн албан дахь гэмт хэрэг, зөрчил, дүрмийн бус харилцаа дэглэлт” гэсэн хамгийн өндөр хувьтай хариулт өгсөн байгаад анхаарал хандуулсан зөв шийдэл байх болно.

Батлан хамгаалах бодлого, зорилтод тусгасан бүх нийтийн оролцоог хангасан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх үндсэн суурь нөхцөл бол эх орноо хамгаалах зохих бэлтгэлтэй иргэдийн нөөц бүрдүүлэх байдаг. Энэхүү нөөцийг бүрдүүлэх хамгийн үр дүнтэй арга нь иргэдийг хугацаат цэргийн албанд бүрэн хамруулахад оршиж байдаг. Өнөөгийн хугацаат цэргийн алба хаах тогтолцоо, хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд цэргийн албанд хамруулах иргэдийн тоог нэмэх боломж үндсэндээ байхгүй гэж болно. Иймээс иргэдийг аль болох өргөнөөр цэргийн албаны сургалт бэлтгэлд хамруулахын тулд өнөөгийн хугацаат цэргийн алба хаалгаж байгаа арга хэлбэрийг өргөжүүлж, иргэд сайн дураар хувцас, хэрэглэлээ өөрөө бэлтгэж, сургалтад хамрагдах хугацаагаа уян хатан, олон сонголттой байдлаар зохицуулах боломжтой цэргийн сургалт, бэлтгэлийн шинэ арга, хэлбэрүүдийг бий болгох шаардлага, эрэлт хэрэгцээ ч байгаа юм.

Иргэд сайн дураар, уян хатан нөхцөлтэйгөөр цэргийн сургалт, бэлтгэлд хамрагдах тогтолцоог бий болгох нь дараах ач холбогдолтой юм. Үүнд:

- Цэргийн бэлтгэлтэй дайчилгааны нөөцийн тоо нэмэгдэх,
- Иргэдээр цэргийн алба хаалгахтай холбоотой улсын төсөвт ирэх ачааллыг багасгах,
- Иргэд хувцас хэрэглэлээ өөрөө бэлдэх нь цэргийн хувцас хэрэглэлэлийн үйлдвэр худалдаа гэсэн эдийн засгийн нэг салбар хөгжих, улмаар цэргийн хувцас, тоног хэрэглэлийн чанар сайжрах,
- Төрийн алба хаах сонирхолтой залуус өөрт тохиромжтой нөхцлөөр цэргийн алба хаах боломж бүрдэх,
- Цэргийн анги, байгууллагуудыг түшиглэн богино хугацааны эрчимжүүлсэн сургалтын төвүүдийг байгуулан ажиллуулснаар офицер, ахлагч нарын цэргийн хэргийн онол, арга зүйн чадвар дээшилж, улмаар анги байгууллагын сургалт бэлтгэл, бэлэн байдалд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

ЭШЛЭЛ АВСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ:

1. https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_18260/
2. Федеральный закон от 28.03.1998 N 53-ФЗ (ред. от 24.09.2022) “О воинской обязанности и военной службе” (с изм. и доп., вступ. в силу с 13.10.2022)
3. https://countrymeters.info/ru/Russian_Federation
4. <https://militarist-info.ru/2022/01/08/chislennost-army-russia-2022/>
5. https://countrymeters.info/ru/Armenia#population_2023
6. <https://regnum.ru/news/polit/3492889.html>
7. <https://kra.ee/kodanik-ja-riigikaitse/riigikaitses-osalemisest/>
8. <https://www.eesti.ee/ru/bezopasnost-i-oborona/srocnaa-sluzba/voinskaa-obazannost>
9. <https://countrymeters.info/ru/Uzbekistan>
10. <https://uzbekistaninfo.ru/vooruzhennye-sily-uzbekistana>
11. <https://parliament.gov.uz/ru/laws/adopted/79/3119/>

**“Хугацаат цэргийн алба хаах тогтолцоо, шинэчлэл” сэдэвт социологийн судалгааны
нэгдсэн дүн**

1. Таны нас

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	16-21 нас	300	14.3	14.3	14.3
	22-27 нас	297	14.2	14.2	28.6
	28-33 нас	315	15.1	15.1	43.6
	34-39 нас	386	18.5	18.5	62.1
	40-45 нас	298	14.2	14.2	76.2
	46-51 нас	234	11.2	11.2	87.5
	52-57 нас	195	9.3	9.3	96.8
	58-аас дээш	66	3.2	3.2	100.0
	Total	2091	100.0	100.0	

2. Таны оршин суугаа газар

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Архангай	46	2.2	2.2	2.2
	Багануур	9	.4	.4	2.6
	Багахангай	3	.1	.1	2.8
	Баян-Өлгий	6	.3	.3	3.1
	Баянгол	72	3.4	3.4	6.5
	Баянзүрх	67	3.2	3.2	9.7
	Баянхонгор	89	4.3	4.3	14.0
	Булган	54	2.6	2.6	16.5
	Говь-Алтай	141	6.7	6.7	23.3
	Говьсүмбэр	27	1.3	1.3	24.6
	Дархан-Уул	64	3.1	3.1	27.6
	Дорноговь	156	7.5	7.5	35.1
	Дорнод	44	2.1	2.1	37.2
	Дундговь	76	3.6	3.6	40.8
	Завхан	3	.1	.1	41.0
	Налайх	2	.1	.1	41.1
	Орхон	3	.1	.1	41.2
	Өвөрхангай	116	5.5	5.5	46.8
	Өмнөговь	76	3.6	3.6	50.4
	Сонгинохайрхан	71	3.4	3.4	53.8
	Сүхбаатар (аймаг)	44	2.1	2.1	55.9
	Сүхбаатар (дүүрэг)	56	2.7	2.7	58.6

	Сэлэнгэ	2	.1	.1	58.7
	Төв	30	1.4	1.4	60.1
	Увс	211	10.1	10.1	70.2
	Хан-Уул	59	2.8	2.8	73.0
	Ховд	296	14.2	14.2	87.2
	Хөвсгөл	4	.2	.2	87.4
	Хэнтий	262	12.5	12.5	99.9
	Чингэлтэй	2	.1	.1	100.0
	Total	2091	100.0	100.0	

3. Боловсрол

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Бага	24	1.1	1.1	1.1
	Бүрэн бус дунд	158	7.6	7.6	8.7
	Бүрэн дунд	613	29.3	29.3	38.0
	Дээд	1296	62.0	62.0	100.0
	Total	2091	100.0	100.0	

4. Ажил, мэргэжил

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Ажилгүй	294	14.1	14.1	14.1
	Төрийн албан хаагч	1460	69.8	69.8	83.9
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	161	7.7	7.7	91.6
	Хувийн хэвшилд ажилладаг	176	8.4	8.4	100.0
	Total	2091	100.0	100.0	

5. Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний талаарх мэдээ мэдээллийг та хаанаас авдаг вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Бусад хүнээс /эцэг эх, хамаатан, найз гэх мэт/	196	9.4	9.4	9.4
	Төрийн байгууллага /Цэргийн штаб/-аас	720	34.4	34.4	43.8
	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс	1175	56.2	56.2	100.0
	Total	2091	100.0	100.0	

6. Таны бодлоор иргэн бүр хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн алба хаах бодит хэрэгцээ, шаардлага байгаа юу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Байгаа	1616	77.3	77.3	77.3
	Байхгүй	122	5.8	5.8	83.1
	Мэдэхгүй	112	5.4	5.4	88.5
	Энэ тийм ч чухал биш	241	11.5	11.5	100.0
	Total	2091	100.0	100.0	

7. “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” нь Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай болон Иргэний цэргийн үүргийн тухай хуулиар тогтоосон иргэн хүний үүрэг гэдгийг та мэдэх үү?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Мэднэ	1997	95.4	95.4	95.4
	Мэдэхгүй	94	4.5	4.5	99.9
	Total	2091	100.0	100.0	

8. Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд та цэргийн албанд явах уу?
"Тийм" гэж хариулсан бол 9-р асуулт, "Үгүй" гэж хариулсан бол 10-р асуултад хариулна уу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Тийм	1532	73.2	73.2	73.3
	Үгүй	559	26.7	26.7	100.0
	Total	2091	100.0	100.0	

9. “8” дугаар асуултад “Тийм” гэж хариулсан бол таны шийдвэрт нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар таны бодол /доорх хариултаас сонгоно уу/:

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нь иргэний үүрэг гэж үзсэн	916	59.8	59.8	68.2
	Эх орноо хамгаалахад өөрийн хувь нэмрээ оруулах	616	40.2	40.2	100.0
	Total	1532	100.0	100.0	

10. “8” дугаар асуултад “Үгүй” гэж хариулсан бол таны шийдвэрт нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар таны бодол /доорх хариултаас сонгоно уу/:

	Frequency	Percent	Valid Percent	Percent
Гэр бүлээ дэмжихийн тулд ажлаа хийх шаардлагатай	338	33.17	33.17	67.4
Сурч байгаа тул сургуулиасаа завсардах сонирхолгүй байна	289	28.37	28.37	81.3
Хүссэн ажилдаа орсон тул ажлаа алдахыг хүсэхгүй байна	178	17.46	17.46	89.8
Цэргийн албыг биеэр бус, мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлж хаах сонирхолтой	214	21	21	100.0
Total	559	100.0	100.0	

11. Таны бодлоор иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахад ямар хүчин зүйл нөлөөлдөг вэ?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Ар гэр бүл, найз нөхдийн шахалт, ятгалгаар цэргийн алба хаадаг	107	5.1	5.1	5.2
Өөрийгөө хөгжүүлэх боломж гэж үзсэн	494	23.6	23.6	28.7
Өөрийн хүч, боломж, тэсвэр хатуужлаа сорьж үзэх	584	28.0	28.0	56.7
Төрийн албанд орохын тулд цэргийн алба хаасан байх шаардлагатай	793	37.9	37.9	94.6
Цэргийн зэвсэг, техник, дүрэмт хувцас сонирхолтой санагдсан	64	3.1	3.1	97.7
Цэргийн сургуульд элсэн орж чадаагүй нөхцөлд байж болох сонголт	48	2.3	2.3	100.0
Total	2091	100.0	100.0	

12. Таны бодлоор иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахаас зайлсхийхэд хүргэдэг ямар хүчин зүйлүүд байдаг вэ?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Ажил, сургууль, гэр бүлээсээ нэг жил хөндийрөх нь хүндрэлтэй санагддаг	258	12.3	12.3	12.3

Аюул, эрсдэлтэй ажил гэж боддог	283	13.5	13.5	25.9
Хүний эрх, эрх чөлөө тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг	224	10.7	10.7	36.6
Цэргийн алба нь амьдралынхаа нэг жилийг зарцуулахаар чухал ач холбогдолтой зүйл гэж үздэггүй	258	12.3	12.3	48.9
Цэргийн албатай холбоотой дэглэлт, дүрмийн бус харьцаа зэрэг сөрөг мэдээлэл их байдаг	1038	49.6	49.6	98.6
Шашин шүтлэг, ёс зүйн зэрэг бусад шалтгаан	30	1.4	1.4	100.0
Total	2091	100.0	100.0	

13. Иргэдийн хугацаат цэргийн алба хаах хүсэл, сонирхлыг идэвхжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах нь зохистой талаар таны бодол:

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
“Оюутан цэрэг” маягийн богино хугацааны эрчимтэй сургалтын хамрах хүрээг өргөжүүлэх	542	25.9	25.9	25.9
Залуучууд ажил, амьдралаа зохицуулан хүссэн цагтаа цэргийн анги, байгууллагатай гэрээ байгуулан богино хугацааны сургалтад хамрагдах замаар албаа хаах нөхцөл бүрдүүлэх	359	17.1	17.1	43.0
Хугацаат цэргийн албыг биеэр хаасан залууст үзүүлэх хөнгөлөлт урамшуулал /сургалтын төлбөр, орон сууцны зээл, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт/-ын тогтолцоог бий болгох	505	24.2	24.2	67.2
Цэргийн албатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох	286	13.7	13.7	80.9
Цэргийн албыг залуус бие бялдар, сэтгэл зүй, амьдрах ухаан, тэсвэр хатуужил, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх хөгжлийн орчин болгон шинэчлэх	399	19.1	19.1	100.0

Total	2091	100.0	100.0	
-------	------	-------	-------	--

14. Таны бодлоор цэргийн алба хаах дараах хугацаануудаас хамгийн тохиромжтой хувилбар аль нь вэ?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
12 сараар хаах	993	47.5	47.5	47.5
18 сараар хаах	76	3.6	3.6	51.1
24 сараар хаах	255	12.2	12.2	63.3
6 сараар хаах	582	27.8	27.8	91.2
8 сараар хаах	81	3.9	3.9	95.0
Жилд 2 хүртэл сараар хувааж хаах замаар 3-4 жилд албаа хааж дуусгах	104	5.0	5.0	100.0
Total	2091	100.0	100.0	

15. Хугацаат цэргийн албыг дараах нөхцөл байдлаар хаахыг иргэнд санал болговол Танд аль хувилбар нь илүү тохиромжтой санагдаж байна вэ? (чухал гэсэн 1-3 хүртэл хариулт сонгох)

1 жилийн хугацаанд цэргийн хэрэгт суралцаад халагдах одоогийн тогтолцоо	880	42.1	47.5	47.5
6 сар зөвхөн цэргийн хэрэгт эрчимтэй суралцаад халагдах	553	26.5	3.6	51.1
1 жил цэргийн алба хаах, ингэхдээ 6 сар цэргийн хэрэгт суралцах, 6 сар бүтээн байгуулалтад оролцох	459	22.0	12.2	63.3
18 сар цэргийн алба хаах, ингэхдээ 9 сар цэргийн хэрэгт суралцах, 9 сар бүтээн байгуулалтад оролцох	128	6.1	27.8	91.2
24 сараар цэргийн алба хаах, ингэхдээ 12 сар цэргийн хэрэгт суралцах, 12 сар бүтээн байгуулалтад оролцох	180	8.6	3.9	95.0
Оюутан цэрэг сургалтаар хугацаат цэргийн алба хаах	555	26.6	5.0	100.0
Иргэн өөрийн сонгосон хугацаандаа уян хатан, хэсэгчлэн сонгож алба хаах боломж олгосон хувилбар	314	15.0	100.0	
Бусад	629	30.1		
Нийт	3698	177	177	

16. Таны бодлоор хугацаат цэргийн алба хаах тогтолцоог яаж шинэчлэх хэрэгтэй вэ? (чухал гэсэн 1-3 хүртэл хариулт сонгох)

Алба хаах хугацааг богино болгож сургалтыг эрчимжүүлэх	708	33.9	47.5	47.5
Алба хаах хугацааг нэмж чанаржуулах	272	13.0	3.6	51.1
Алба хаах хугацаа, хэлбэрийг уян хатан олон хувилбартай болгож хамрагдах иргэдийг нэмэгдүүлэх	519	24.8	12.2	63.3
Хугацаат цэргийн албаны сургалт, бэлтгэлийг сайжруулах	420	20.1		
Хугацаат цэргийн албын орчин нөхцөлийг сайжруулах	537	25.7	27.8	91.2
Цэргийн албан дахь дарамт, шахалт, дэглэлтийг арилгах	750	35.9	3.9	95.0
Цэргийн албан дахь гэмт хэрэг зөрчил, хөдөлмөрийн осол зөрчлийг багасгах	421	20.1		

ЕБС-ийн сурагч байхаас нь эх оронч үзэл төлөвшүүлж цэргийн алба хаах хүсэл сонирхол төрүүлэх сургалтыг явуулах	164	7.8	5.0	100.0
Цэргийн албыг 2 жил болгож улс эх орныхоо бүтээн байгуулалтын ажилд оролцуулах, тэднийг мэргэшүүлэх шаардлагатай	101	4.8		
Эмэгтэйчүүдийг цэргийн албанд татагдах эрхийг бий болгох	26	1.2		
Эрэгтэйчүүд их сургуульд элсэн суралцахын тулд цэргийн алба хаасан байх	12	0.6		
Бусад	603	28.8	177	
Нийт	4533	211.8		

1. Судалгаанд оролцогсдын зэвсэгт хүчний талаарх мэдээ мэдээллийг хаанаас авдаг талаарх асуулгыг нас, боловсрол, ажил мэргэжлээр ангилан авч үзвэл:

Нас

		Бусад хүнээс /эцэг эх, хамаатан, найз гэх мэт/	Төрийн байгууллага /Цэргийн штаб/- аас	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс	Total
Таны нас	16-21 нас	3.5%	4.39%	6.36%	300
	22-27 нас	1.48%	4.44%	8.27%	297
	28-33 нас	1.05%	4.97%	9.03%	315
	34-39 нас	1.09%	6.64%	10.71%	386
	40-45 нас	0.95%	4.59%	8.6%	296
	46-51 нас	0.47%	4.39%	6.31%	234
	52-57 нас	0.2%	3.68%	5.35%	195
	58-аас дээш	0.43%	1.29%	1.43%	66
Total		9.37%	34.4%	56.19%	100%



Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой мэдээллийг ямар сувгаар авдаг болох дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогсдын талаас илүү хувь буюу 56.19% нь хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс олж авдаг ба 34.4% нь төрийн байгууллагууд болон цэргийн штабаас гаргаж буй мэдээллээс авдаг бол танилын хүрэнээс мэдээлэл авдаг иргэдийн тоо хамгийн бага буюу 9.37% харагдаж байна.

Боловсрол

			Бусад хүнээс /эцэг эх, хамаатан, найз гэх мэт/	Төрийн байгууллага /Цэргийн штаб/- аас	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс	Total
Боловсрол	Бага	Count	11	2	11	24
		% of Total	0.5%	0.1%	0.5%	1.1%
	Бүрэн бус дунд	Count	24	37	97	158
		% of Total	1.1%	1.8%	4.6%	7.6%
	Бүрэн дунд	Count	92	197	324	613
		% of Total	4.4%	9.4%	15.5%	29.3%
	Дээд	Count	69	484	741	1294
		% of Total	3.3%	23.2%	35.5%	61.9%
Total		Count	196	720	1173	2089
		% of Total	9.4%	34.5%	56.2%	100.0%

Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой мэдээллийг аль сувгаар авдаг болохыг боловсролын түвшнээр ангилан дээрх хүснэгтээс харахад хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс гол төлөв мэдээллийг авдаг болох нь харагдаж байна.

Ажил, мэргэжил


		Бусад хүнээс /эцэг эх, хамаатан, найз гэх мэт/	Төрийн байгууллага /Цэргийн штаб/- аас	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс	Total
Ажил, мэргэжил	Ажилгүй	3.8%	3.2%	7.1%	14.1%
	Төрийн албан хаагч	3.3%	28.2%	38.3%	69.8%
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	1.0%	1.3%	5.4%	7.7%
	Хувийн хэвшилд ажилладаг	1.4%	1.7%	5.4%	8.4%
Total		9.4%	34.5%	56.2%	100.0%

Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой мэдээллийг аль сувгаар авдаг болохыг ажил мэргэжлээр ангилан үзвэл мөн адил хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнээс авдаг болохыг харж байна. Харин төрийн албан хаагчдын дунд төрийн байгууллага /Цэргийн штаб/-аас мэдээллээ авдаг хүмүүс цөөнгүй байна.

2. Судалгаанд оролцогсдыг **“Хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн алба хаах бодит хэрэгцээ, шаардлага”** байгаа талаарх асуултыг нас, боловсрол, ажил мэргэжлээр авч үзвэл:

Нас

		Байгаа	Байхгүй	Мэдэхгүй	Энэ тийм ч чухал биш	Total
1. Таны нас	16-21 нас	10.6%	1.1%	1.5%	1.2%	14.4%
	22-27 нас	9.6%	1.2%	0.8%	2.6%	14.2%
	28-33 нас	12.0%	1.0%	0.6%	1.4%	15.1%
	34-39 нас	14.2%	1.1%	1.4%	1.8%	18.5%
	40-45 нас	11.2%	0.5%	0.6%	1.9%	14.2%
	46-51 нас	8.9%	0.7%	0.3%	1.3%	11.2%
	52-57 нас	7.9%	0.3%	0.1%	1.0%	9.3%
	58-аас дээш	2.9%	0.0%	0.0%	0.2%	3.2%
		77.3%	5.8%	5.4%	11.5%	100.0%



Судалгаанд нийт оролцогсдын хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн алба хаах бодит хэрэгцээ, шаардлага байгаа тухайд асуултад ихэнх нь буюу 77.3% “Байгаа” гэж хариулсан бол “Байхгүй” 5,8%, “Мэдэхгүй” 5.4%, “Энэ тийм ч чухал биш” 11.5% гэсэн харилтууд маш бага хувийг

эзэлж байна.

Боловсрол

		Байгаа	Байхгүй	Мэдэхгүй	Энэ тийм ч чухал биш	Total
Боловсрол	Бага	0.9%	0.0%	0.1%	0.0%	1.1%
	Бүрэн бус дунд	5.8%	0.6%	0.6%	0.6%	7.6%

Бүрэн дунд	22.2%	1.8%	2.0%	3.4%	29.3%
Дээд	48.4%	3.4%	2.7%	7.4%	61.9%
Total	77.3%	5.8%	5.4%	11.5%	100.0%

Ажил, мэргэжил

		Байгаа	Байхгүй	Мэдэхгүй	Энэ тийм ч чухал биш	Total
Ажил, мэргэжил	Ажилгүй	10.2%	0.9%	1.5%	1.5%	14.1%
	Төрийн албан хаагч	56.0%	3.2%	3.3%	7.4%	69.8%
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	5.6%	0.8%	0.1%	1.2%	7.7%
	Хувийн хэвшилд ажилладаг	5.5%	1.1%	0.4%	1.4%	8.4%
	Total	77.3%	5.8%	5.4%	11.5%	100.0%

3. Судалгаанд оролцогсдын **“Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд та цэргийн албанд явах уу?”** гэх асуултыг нас, боловсрол, ажил мэргэжлээр ангилж үзэн дараах байдлаар ангилан харуулав:

Нас

		Тийм	Үгүй	
1. Таны нас	16-21 нас	9.7%	4.6%	14.4%
	22-27 нас	9.0%	5.3%	14.2%
	28-33 нас	11.6%	3.4%	15.1%
	34-39 нас	13.5%	5.0%	18.5%
	40-45 нас	10.6%	3.6%	14.2%
	46-51 нас	8.5%	2.7%	11.2%
	52-57 нас	7.7%	1.7%	9.3%
	58-аас дээш	2.8%	0.4%	3.2%
Total		73.2%	26.8%	100.0%



Судалгаанд нийт оролцогсдын **“Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд та цэргийн албанд явах уу?”** гэсэн асуултад ихэнх нь буюу 73.2% “Тийм” гэж хариулсан бол 26.8% “Үгүй” гэж хариулсан байна.

Боловсрол

		Тийм	Үгүй	Total
3. Боловсрол	Бага	0.8%	0.3%	1.1%
	Бүрэн бус дунд	5.7%	1.8%	7.6%
	Бүрэн дунд	22.5%	6.9%	29.3%
	Дээд	44.2%	17.7%	61.9%
Total		73.2%	26.8%	100.0%

Ажил, мэргэжил

		Тийм	Үгүй	
Ажил, мэргэжил	Ажилгүй	9.8%	4.3%	14.1%
	Төрийн албан хаагч	52.7%	17.1%	69.8%
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	5.2%	2.5%	7.7%
	Хувийн хэвшилд ажилладаг	5.6%	2.9%	8.4%
Total		73.2%	26.8%	100.0%

4. Судалгаанд оролцогсдын **“Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд та цэргийн албанд явах уу?”** гэх асуултад **“Тийм”** гэж хариулсан хүмүүст ямар хүчин зүйл нөлөөлсөн болохыг насаар дараах байдлаар ангилан харуулав:

Нас

		Хариулт сонгоогүй хүмүүс	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нь иргэний үүрэг гэж үзсэн	Эх орноо хамгаалахад өөрийн хувь нэмрээ оруулах	
Таны нас	16-21 нас	3.5%	5.5%	5.3%	14.4%
	22-27 нас	4.4%	5.6%	4.2%	14.2%
	28-33 нас	2.8%	6.7%	5.5%	15.1%
	34-39 нас	3.6%	8.5%	6.4%	18.5%
	40-45 нас	3.0%	6.7%	4.5%	14.2%
	46-51 нас	2.1%	6.0%	3.1%	11.2%
	52-57 нас	1.2%	6.1%	2.0%	9.3%
	58-аас дээш	0.2%	2.2%	0.8%	3.2%
Total		20.8%	47.3%	31.8%	100.0%




Судалгаанд нийт оролцогсдын “Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд та цэргийн албанд явах уу?” гэсэн асуултад тийм гэж хариулсан хүмүүсийн 47,3% нь “Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нь иргэний үүрэг гэж үзсэн” гэх сонголтыг сонгосон байна. Үлдсэн хувьд нь “Эх орноо хамгаалахад өөрийн хувь нэмрээ оруулах”- 47.3%, “Хариулт сонгоогүй

хүмүүс”- 20.8%-ыг тус тус эзэлж байна.

5. Судалгаанд оролцогсдын “Хуулийн дагуу хугацаат цэргийн албанд татах тухай “Зарлан дуудах” хуудас ирсэн тохиолдолд та цэргийн албанд явах уу?” гэх асуултад “Үгүй” гэж хариулсан хүмүүст ямар хүчин зүйл нөлөөлсөн болохыг насаар дараах байдлаар ангилан харуулав:


		Хариулт сонгоогүй хүмүүс	Гэр бүлээ дэмжихийн тулд ажлаа хийх шаардлагатай	Сурч байгаа тул сургуулиасаа завсардах сонирхолгүй байна	Хүссэн ажилдаа орсон тул ажлаа алдахыг хүсэхгүй байна	Цэргийн албыг биеэр бус, мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлж хаах сонирхолтой	
Таны нас	16-21 нас	6.0%	1.4%	4.7%	1.0%	1.3%	14.4%
	22-27 нас	6.5%	2.9%	1.5%	2.2%	1.1%	14.2%
	28-33 нас	7.9%	2.4%	1.5%	1.5%	1.7%	15.1%
	34-39 нас	9.6%	4.0%	1.5%	1.4%	1.9%	18.5%
	40-45 нас	7.6%	2.3%	2.3%	0.8%	1.2%	14.2%
	46-51 нас	6.0%	1.4%	1.5%	0.9%	1.5%	11.2%
	52-57 нас	5.6%	1.5%	0.7%	0.7%	0.9%	9.3%
	58-аас дээш	2.1%	0.2%	0.2%	0.1%	0.6%	3.2%
Total		51.2%	16.2%	13.8%	8.5%	10.2%	100.0%



Дээрх тоон баримтаас авч үзэхэд 16-21 насны залуучуудын цэргийн албанд татагдахгүй гол шалтгаан бол “сурч байгаа сургуулиасаа завсардах сонирхолгүй байна” бол 22-оос дээш насныхны хувьд “гэр бүлээ дэмжихийн тулд ажлаа хийх шаардлагатай” гэсэн хариултыг илүү сонгосон байна.

6. Судалгаанд оролцогсдын “Таны бодлоор иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахад ямар хүчин зүйл нөлөөлдөг вэ? гэх асуултад нас насныханд ямар хүчин зүйл нөлөөлдгийг дараах байдлаар харуулав:

		Ар гэр бүл, найз нөхдийн шахалт, ятгалгаар цэргийн алба хаадаг	Өөрийгөө хөгжүүлэх боломж гэж үзсэн	Өөрийн хүч, боломж, тэсвэр хатуужлаа сорьж үзэх	Төрийн албанд орохын тулд цэргийн алба хаасан байх шаардлагатай	Цэргийн зэвсэг, техник, дүрэмт хувцас сонирхолтой санагдсан	Цэргийн сургуульд элсэн орж чадаагүй нөхцөлд байж болох сонголт	
Таны нас	16-21 нас	0.8%	3.1%	4.6%	4.5%	0.9%	0.5%	14.4%
	22-27 нас	1.2%	3.4%	3.1%	5.3%	0.8%	0.4%	14.2%
	28-33 нас	0.9%	2.8%	4.9%	5.6%	0.4%	0.4%	15.1%
	34-39 нас	0.5%	4.1%	5.8%	7.2%	0.5%	0.4%	18.5%
	40-45 нас	0.8%	2.8%	3.7%	6.3%	0.2%	0.3%	14.2%
	46-51 нас	0.5%	3.5%	2.8%	4.1%		0.2%	11.2%
	52-57 нас	0.3%	3.2%	2.3%	3.4%	0.2%	0.0%	9.3%
	58-аас дээш	0.1%	0.7%	0.8%	1.6%			3.2%
Total		5.1%	23.6%	28.0%	38.0%	3.1%	2.3%	100.0%




7. Судалгаанд оролцогсдын “Таны бодлоор иргэд хугацаат цэргийн алба биеэр хаахаас зайлсхийхэд хүргэдэг ямар хүчин зүйлүүд байдаг вэ? гэх асуултад нас насныханд ямар хүчин зүйл нөлөөлдгийг дараах байдлаар харуулав:

		Ажил, сургууль, гэр бүлээсээ нэг жил хөндийрөх нь хүндрэлтэй санагддаг	Аюул, эрсдэлтэй ажил гэж боддог	Хүний эрх, эрх чөлөө тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг	Цэргийн алба нь амьдралынх аа нэг жилийг зарцуулахаа р чухал ач холбогдолтой зүйл гэж үздэггүй	Цэргийн албатай холбоотой дэглэлт, дүрмийн бус харьцаа зэрэг сөрөг мэдээлэл их байдаг	Шашин шүтлэг, ёс зүйн зэрэг бусад шалтгаан	
Таны нас	16-21 нас	2.7%	2.2%	2.1%	1.8%	5.1%	0.4%	14.4%
	22-27 нас	2.5%	1.7%	1.9%	2.1%	5.9%	0.1%	14.2%
	28-33 нас	1.7%	2.3%	1.4%	1.8%	7.8%	0.0%	15.1%
	34-39 нас	2.1%	2.5%	1.8%	2.3%	9.5%	0.2%	18.5%

40-45 нас	1.2%	1.9%	1.0%	1.4%	8.4%	0.2%	14.2%
46-51 нас	1.3%	1.9%	1.1%	1.2%	5.6%	0.2%	11.2%
52-57 нас	0.5%	0.7%	1.1%	1.4%	5.5%	0.1%	9.3%
58-аас дээш	0.2%	0.2%	0.3%	0.3%	1.9%	0.1%	3.2%
Total	12.4%	13.5%	10.7%	12.3%	49.7%	1.4%	100.0%

Дээрх судалгаанаас авч үзэхэд бүх насны ангилалд **“Цэргийн албатай холбоотой дэглэлт, дүрмийн бус харьцаа зэрэг сөрөг мэдээлэл их байдаг”** хариултыг их сонгосон байгаа нь тус асуудлаас цэргийн албанаас зайлсхийх явдал их байна гэж харж болохоор байна.




8. Судалгаанд оролцогсдын “Иргэдийн хугацаат цэргийн алба хаах хүсэл, сонирхлыг идэвхжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах нь зохистой талаар таны бодол” гэх асуултад нас насныхан хэрхэн хариулж буйг дараах байдлаар харуулав:

“Оюутан цэрэг” маягийн богино хугацааны эрчимтэй сургалтын хамрах хүрээг өргөжүүлэх	Залуучууд ажил, амьдралаа зохицуулан хүссэн цагтаа цэргийн анги, байгууллагатай гэрээ байгуулан богино хугацааны сургалтад хамрагдах замаар албаа хаах нөхцөл бүрдүүлэх	ХЦА-ыг биеэр хаасан залууст үзүүлэх хөнгөлөлт урамшуулал /сургалтын төлбөр, орон сууцны зээл, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт/-ын тогтолцоог бий болгох	Цэргийн албатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох	Цэргийн албыг залуус бие бялдар, сэтгэл зүй, амьдрах ухаан, тэсвэр хатуужил, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх хөгжлийн орчин болгон шинэчлэх	Total
---	---	---	---	---	-------


Таны нас	16-21 нас	6.0%	2.3%	2.6%	1.6%	1.9%	14.4%
	22-27 нас	4.0%	3.0%	3.3%	2.2%	1.8%	14.2%
	28-33 нас	3.5%	2.6%	4.2%	1.7%	3.0%	15.1%
	34-39 нас	4.0%	3.4%	4.8%	2.6%	3.5%	18.5%
	40-45 нас	3.5%	2.2%	3.5%	2.1%	2.8%	14.2%
	46-51 нас	2.6%	1.5%	2.4%	1.7%	2.9%	11.2%
	52-57 нас	1.9%	1.6%	2.4%	1.3%	2.1%	9.3%
	58-аас дээш	0.3%	0.5%	0.9%	0.3%	1.1%	3.2%
Total		25.9%	17.1%	24.2%	13.7%	19.1%	100.0%

Дээрх судалгаанаас авч үзэхэд судалгаанд нийт оролцогчид болон цэргийн насны залуучуудын дунд ““Оюутан цэрэг” маягийн богино хугацааны эрчимтэй сургалтын хамрах хүрээг өргөжүүлэх” хариултыг хамгийн их (25.9%) сонгосон байгаа бол “Хугацаат цэргийн албыг биеэр хаасан залууст үзүүлэх хөнгөлөлт урамшуулал /сургалтын төлбөр, орон сууцны зээл, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт/-ын тогтолцоог бий болгох” хариулт удаалсан (24.2%) харагдаж байна



9. Судалгаанд оролцогсдын “Таны бодлоор цэргийн алба хаах дараах хугацаануудаас хамгийн тохиромжтой хувилбар аль нь вэ?” гэх асуултад нас насныханд хэрхэн үзэж байгааг дараах байдлаар харуулав:

		12 сараар хаах	18 сараар хаах	24 сараар хаах	6 сараар хаах	8 сараар хаах	Жилд 2 хүртэл сараар хувааж хаах замаар 3-4 жилд албаа хааж дуусгах	
Таны нас	16-21 нас	5.5%	0.1%	0.8%	6.5%	0.9%	0.6%	14.4%
	22-27 нас	5.5%	0.4%	1.1%	5.2%	0.7%	1.3%	14.2%
	28-33 нас	7.9%	0.4%	1.6%	3.7%	0.7%	0.7%	15.1%
	34-39 нас	10.0%	0.6%	1.5%	4.9%	0.4%	1.0%	18.5%
	40-45 нас	7.5%	0.6%	1.6%	3.5%	0.5%	0.5%	14.2%
	46-51 нас	5.8%	0.6%	1.8%	2.2%	0.3%	0.5%	11.2%
	52-57 нас	4.0%	0.6%	2.8%	1.3%	0.3%	0.3%	9.3%
	58-аас дээш	1.4%	0.2%	1.0%	0.4%	0.1%	0.1%	3.2%
Total		47.5%	3.5%	12.2%	27.9%	3.9%	5.0%	100.0%



Судалгаанд оролцогсдын бараг тал хувь буюу 47.5% нь одоо байгаа нэг жилийн алба хаахыг тохиромжтой гэж үзсэн бол 6 сараар хаах хувилбарыг 27.9% сонгосон байна.